

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН**

**1.1 "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагаагны хөтөлбөр, "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2050" бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

**1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтооолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-өөс Хан-Уул дүүрэг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх 4 бүлгийн 8 арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн гаргахад 96.2 хувьтай хэрэгжсэн бөгөөд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 06/22 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2021 оны эхний хагас жилийн биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч, нэгтгэн боловсруулахад 63 хувьтай хэрэгжсэн байна. Хэрэгжилтийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр бэлтгэж байна.

**ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:**

**"Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд:**

"Ковид-19" халдварт цар тахлын үед дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага болон тусгаарлан ажиглах байраар ашиглах боломжтой объектын судалгаа, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг гаргасан.

- Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй эмийн сан-135
- Улсын 3 эмнэлэгт эмч-219, сувилагч-193, асрагч-51, бусад ажилчид-223
- Хувийн эмнэлгүүдэд эмч-662, сувилагч-402, бусад ажилчид-743
- Хувийн ортой эмнэлгүүдэд нийт хэвтэн эмчлүүлэх орны тоо-830, их эмч-170, сувилагч-301
- Коронавируст халдварт /Ковид-19/-ын үед сайн дурын ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах иргэдийн судалгаа, нөхцөл байдал хүндэрсэн үед сайн дураараа ажиллах хувийн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн ажилтны судалгаа, эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хувцас, ариутгалын бодисын нөөцийн судалгааг гаргаж, хяналт тавьсан.

**"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилогоо, эмчилгээнд алсын технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:**

"Цахим эмч" апликацийн нэвтрүүлэх ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тогтооолоор батлагдсан "Эрүүл


**дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд "Цахим эмч" төслийг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран боловсруулсан.**

**"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**

"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрт дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, үзлэг оношилгоонд хамруулах заалтыг тусган батлуулсан. Тус хөтөлбөрөөс санхүүжилт хүссэн төслийг Эрүүл мэндийн төвтэй хамтран боловсруулж, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулах саналыг хүргүүлсэн.

**Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хуртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд сууринсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх зорилтын хүрээнд:**

Цар тахлын үед идэвхтэй хөдөлгөөн хийх, биеийн дархлааг дэмжих зорилготой "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021" арга хэмжээг Биеийн тамир, спорт хороотой хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Хан-Уул дүүргийн 1343 иргэн хамрагдаж, нийт 16417 км зам гүйсэн амжилтаар нийслэлийн бүсэд 3 дугаар байрт шалгарсан. Арга хэмжээнд идэвхтэй оролцсон оролцогсдыг дүүргийн Засаг даргын Тамгын газар болон ивээн тэтгэгч байгууллагууд шагнаж урамшуулсан.



**Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бурдуулэх зорилтын хүрээнд:**

Дүүргийн "Албан бус насан туршийн боловсролын төвтэй хамтран нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн видео хичээлийг бэлтгэн хүргэхээр шийдвэрлэж, хороодын Хөгжлийн нийгмийн ажилтнуудад Монгол бичгийн хичээлийн видео, хичээл болон сурх бичгийг олгосон.

**"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн үнэлээмжийг хөдөлмөрийн бутээмж, гүйцэтгэлд сууринсан тогтолцоонд шилжүүлэх зорилтын хүрээнд:**

Хүүхдийн хүмүүжил, төлөвшил болон танин мэдэхүйн сэдвээр дүүргийн нийт сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудын дунд "Эко күйз" асуулт, хариултын цахим уралдааныг Боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Уралдаанд оролцогчид 25 хоногийн хугацаанд нийт 250 асуултад хариулж мэдлэг чадвараа сорьсон.

**Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тур хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангах ажлын хүрээнд:**

Хан-Уул дүүргийн 7 дугаар хороонд байрлах Гэр бүлийн хүчирхийлийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 125 иргэн үйлчлүүлсэн байна. Үүнээс: Том хүн-5, Хүүхэд-120.

## Хүүхдийн насны ангиллаар авч үзвэл:

Насны ангиал	0-3 нас	4-6 нас	7-9 нас	10-14 нас	15-18 нас
Хүүхдийн тоо	35	33	17	16	19

#### Хүүхдийн өртсөн зөрчлийн хэлбэрүүд:

Хүчирхийллийн хэлбэр	Хараа хяналтгүй	Үл хайхрах	Бие махбодийн	Хүний наймаанд өртсөн	Төөрсөн	Сэтгэл санаа	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн
Хүүхдийн тоо	6	97	11	0	1	6	4



Тус төвийн угтах өрөөний дээврийн засварын ажил болон гал тогооны өрөөний мөөгэнцрийг засаж, агааржуулалтыг сайжруулах шүүгч хоолой сууринуулсан.

### Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нөөцийн махны худалдааг 34 дэлгүүрээр 120 тн мах, 2021 оны 05, 06 дугаар сарын амралтын өдрүүдэд нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 10 удаа, давхардсан тоогоор 25 байршилд 173,9 тн махыг тус тус худалдаалах ажлыг зохион байгуулж, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодтой хамтран халдварт хамгааллын дэглэм, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Нийт 293.9 тонн нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, махны хангамжийг нэмэгдүүлж ажилласан.



Засгийн газрын 2021 оны "Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 110 дугаар тогтоолын дагуу 210 малчин өрхийг 100.000 төгрөгийн буцалтгүй тусламжинд хамруулсан. Мен малчин, мал бүхий этгээдэд төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын материалыг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбогдуулан малчин, мал бүхий иргээдэд мэдээлэл өгч ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас зохион байгуулсаан "Мал сүргийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэн аян"-ы хүрээнд "Шилмэл мал" сүрэг хоршоотой хамтран дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх хээлтэгч 1612 үхрийг бүртгэлжүүлж ээмэгжүүлэхээр төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар 213 үхрийг ээмэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.



Мөн Нийслэлийн Мал эмнэлгийн газартай хамтран "Бруцеллёзгүй дүүрэг" арга хэмжээг хэрэгжүүлэн мал сүрэгт нь бруцеллёз өвчин илрээгүй 463 өрхөд мал эмнэлгийн тасагтай хамтран "Эрүүл сүрэгтэн" гэрчилгээг олгож, иргэдэд экологийн цэвэр сүү нийлүүлэх нөхцлийг бурдүүлж ажилласан.

Дүүргийн Яармаг ОНӨААТҮГ-т байрлах "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвд 36 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг борлуулсан. 2021 оны 04 дүгээр сараас эхлэн цар тахлын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож, цаашид "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг хүн амын нягтаршил ихтэй, ашигтай талбай руу нүүлгэн шилжүүлэх ажлыг дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй хамтран судалж, холбогдох байгууллагуудад танилцуулга бэлтгэж Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих газарт хүргүүлсэн.



Салбарын ойг тохиолдуулан төрийн дээд одон медальд 17, салбарын шагналд 112, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын нэрэмжит шагналд 18, нийт 147 ажилтан, ажилтан албан хаагчдын материалыг хүлээн авч, дэмжин холбогдох байгууллагуудад уламжилж ажилласан.

### **1.3 Улсын болон нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/164, А/185 дугаар захирамжуудаар Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 665.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		Төсөвт өртөг	2021 онд		
Гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн-2					
1	Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж	350.0	350.0	20	4 багцтай бөгөөд "Сетунари" ХХК "Ивээлтгүн" ХХК "ITZone" ХХК "Хашхан" ХХК-үүд шалгарсан. 2021.06.04-нд гэрээ байгуулах

					зөвлөмжийг нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
2	Эрүүл мэндийн төвийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж /Хашчагнуур ΘЭМТ/	10.0	10.0	7	"Медбуян" ХХК шалгарсан. 2021.06.04-нд гэрээ байгуулах зөвлөмжийг нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.
Тендер зарласан-1					
3	Халуун усны барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төв болгон засварлах.	205.0	100.0	6	2021.05.11-нд тендер зарласан боловч аж ахуйн нэгж, байгууллагаас тендер ирээгүй тул 2021.06.18-нд 2 дахь удаа тендер зарласан. 2021.07.22-нд нээлт хийнз.
Тендер зарлах шатанд-1					
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх.	100.0	100.0	6	Тоног төхөөрөмжийн судалгааг гарган, техникийн тодорхойлолтыг батлуулж, Худалдан авах ажиллагааны албанад хүлээлгэн өгсөн. Тендерийн баримт бичиг боловсруулж байна.
	Нийт	665.0	560.0		

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажлын саналыг дэргэдэх хэлтэс, албадаас авч, нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 06/580 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн тус саналуудыг Сангийн Яамны [www.pimis.publicinvestment.gov.mn](http://www.pimis.publicinvestment.gov.mn) цахим системд холбогдох мэдээллийн хамт үнэлж, оруулсан.

Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүнийг бууруулах ажлын хүрээнд Хан-Уул дүүрэгт шинээр барих шаардлагатай хатуу хүчилттай авто зам, авто замын орц, гарц чөлөөлөх байршилын судалгаа болон сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай хороодын судалгааг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Зам, тээврийн асуудал хариуцсан төслийдийн удирдагч Б.Одсүрэнд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны A/37, A/237, A/285, A/288 дугаар захирамжуудаар нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2,080.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх, дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хучин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		Төсөвт өртөг	2020 онд		
Гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн-2					
1	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг худалдан авах.	23.7	23.7	4	"Ай Ти Зон" ХХК шалгарсан.
2	Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөрөнгө оруулалт, тавилга, компьютер, тоног төхөөрөмж /9, 10, 12, 13, 14, 16, 21-р хороо/	400.0	400.0	-	2021.05.13-нд тендер зарласан. 2021.06.15-нд нээлт хийсэн.
Үнэлгээ хийгдэж байгаа-3					
3	Дүүргийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн компьютер, тоног	100.0	100.0	20	2021.04.29-нд тендер зарласан. 2021.05.31-нд нээлт хийсэн.

	техеөрөмж, багаж хэрэгсэл /ХУД/				
4	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн сантехникийн засвар, үйлчилгээ	197.3	197.3	4	2021.05.14-нд тендер зарласан. 2021.06.15-нд нээлт хийсэн.
5	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар ХУД 1, 2, 15, 17 дугаар хороо/	400.0	400.0	-	2021.05.12-нд тендер зарласан. 2021.06.14-нд нээлт хийсэн.
Тендер зарласан-1					
6	Хүүхдийн тоглоомын талбай /ХУД 1 дүгээр хороо/	70.0	70.0	1	2021.05.17-нд тендер зарласан. 2021.06.28-нд нээлт хийнэ.
7	Хүүхдийн тоглоомын талбай /ХУД 20 дугаар хороо/	70.0	70.0	20	2021.05.17-нд тендер зарласан. 2021.06.28-нд нээлт хийнэ.
8	Хүүхдийн тоглоомын талбай /ХУД 18 дугаар хороо/	70.0	70.0	18	2021.05.17-нд тендер зарласан. 2021.06.28-нд нээлт хийнэ.
9	Хан хиллсээс Эрдэнийн төгөл хотхон руу хүрэх далангийн шат, явган хүний зам /ХУД 17 дугаар хороо/	70.0	70.0	17	2021.05.17-нд тендер зарласан. 2021.06.28-нд нээлт хийнэ.
10	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /ХУД 1, 2, 19 дүгээр хороо/	65.0	65.0	1, 2, 19	2021.05.24-нд тендер боловч аж ахуйн нэгж, байгууллагаас тендер ирээгүй тул 2021.06.17-нд 2 дахь удаа тендер зарласан. 2021.06.25-нд нээлт хийнэ.
Тендер зарлах шатанд-1					
11	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил /9, 10, 16, 21-р хороо/	400.0	400.0	9, 10, 16, 21	Ажлын даалгаврууд батлагдсан.
Техникийн тодорхойлолт боловсруулж байгаа-2					
12	Боловсролын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг худалдан авах	400.0	400.0	-	Тоног төхөөрөмжийн судалгаа хийгдэж байна.
13	Хог тээвэрлэх авто машин худалдан авах, хогийн цэгийн тохижилт хийх /ХУД 1, 2, 20 дугаар хороо/	120.0	120.0	-	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих тесэл, арга хэмжээнүүдэд өөрчлөлт орох тул зогсоосон.
	Нийт	2,080.0	2,080.0		

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин барилгажуулах талаар:

Дүүргийн 10 дугаар хорооны ашиглалтын шаардлага хангахгүй 34, 35 дугаар байрнуудын үнэлгээг өнөөгийн ханшаар дахин үнэлэх дүүргийн Засаг даргын захирамж гарсан.

Дүүргийн 10 дугаар хорооны ашиглалтын шаардлага хангахгүй 34, 35, 11-р хорооны Сүрьеэгийн 20, 12-р хорооны 39-р байрнуудын дахин төлөвлөлтийн ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх саналыг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 06/580 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Дүүргийн 20 дугаар хорооны ашиглалтын шаардлага хангахгүй Арьс ширний 31 дүгээр байрыг дахин төлөвлөн барилгажуулах тесэл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд ажиллаж иргэний мэдээллийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дуаар сарын 17-ны өдрийн 06/822 дугаар албан бичгээр Хот байгуулалт хөгжлийн газарт хүргүүлсэн.

Дүүргийн 13 дугаар хорооны ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон 1, 2, 3, 4, 5, 2A-10 дугаар байрны оршин суугч иргэдээс дахин төлөвлөлтийг зөвшөөрсөн болон эс зөвшөөрсөн эсэх саналыг авч байна.

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх талаар:

Гэр хорооллыг дахин барилгажуулах ажлын хүрээнд 4 дүгээр хороонд "Андын зам Констракшн" ХХК 760 айлын 40 га газрыг дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлж, 3547 айлын орон сууцны хотхоныг 2025 онд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Дүүргийн 9 дүгээр хороонд 200 өрхийг дэд бутцэд холбох хүчин чадал бүхий дэд бутцийн төв байгуулах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 06/580 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

**Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 11 дүгээр тогтооолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 21, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 2 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэршил	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/	Ажлын явц
1	Зураг төсөв	-	200.0	Зургийн ажлын жагсаалтыг ДИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 16 дугаар захирамжаар батлуулсан. Жагсаалтын дагуу ажлын даалгавруудыг батлуулан, зөвлөх үйлчилгээ үзүүлэх шууд гэрээ байгуулах ажиллаж байна.
Хэрэгжиж дууссан - 1				
2	Төрийн байгууллагуудын хэрэгцээнд үйлчилгээний авто машин худалдан авах.	-	40.0	"Юникплайтс" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Авто машинууд нийлүүлэгдсэн.
Гэрээ байгуулагдсан - 2				
3	"Эко ахмадын сувилал" ОНӨААТҮГ-ын гадна ногоон байгууламж, тохижилтын ажил.	8	100.0	"Ган хэлхээ констракшн" ХХК шалгарсан.
4	"Эко ахмадын сувилал" ОНӨААТҮГ-т шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, хэргэсэл худалдан авах.	8	314.0	Ажил 2 багцтай бөгөөд "Дегамонгол" ХХК, "Хашхан" ХХК-үүд шалгарсан.
Гэрээ байгуулах шатанд-1				
5	Туул голын эрэг дагуу эко зурvas байгуулах /үргэлжлэл/	20	600.0	"Наранбосголт" ХХК шалгарсан.
Үнэлгээ хийгдэж байгаа-2				
6	Гүний худаг байгуулах.	9, 11, 12, 13, 14,	240.0	2021.05.13-нд тендер зарлаж, 2021.06.14-нд нээлт хийсэн. 2 компани тендер ирүүлсэн.
7	"Хан-Уул зам засвар, арчлалт" ОНӨААТҮГ-т авто машин, техник хэргэсэл, шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх.	-	310.0	2021.05.05-нд тендер зарласан. 2021.06.07-нд нээлт хийсэн.
Тендер зарлах шатанд-5				
8	Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих.	-	2,000.0	Ажлын даалгаврыг батлуулан Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн.
9	Орчны тохижилт хийх.	3, 15, 18, 20	240.0	2021.06.14-нд нээлт хийсэн боловч тендер ирээгүй тул дахин зарлана.
10	Орчны тохижилт хийх.	4, 10, 12, 14, 16, 21	360.0	Зураг төсвийг ХУД-ийн ХААА-нд хүлээлгэн өгсэн.
11	Нийтийн зориулалттай орон сууцны засвар, цахилгааны шугам татах.	10, 13, 16	300.0	2024.04.24-нд тендер зарлаж, 2021.05.26-нд нээлт хийсэн. Компани тендерийн

				материал ирүүлээгүй тул дахин тендер зарлана.
12	Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн байрны фасад, дээвэр засвар.	6, 20	220.0	Зураг төсвийг ХҮД-ийн ХААА-нд хүлээлгэн өгсөн.
Зураг төсөв хийгдэж байгаа-1				
13	Нийтийн зориулалттай орон сууцны засвар.	2, 19	260.0	Ажлын даалгавар батлуулсан. Зураг төсөв хийгдэж, магадлалын дүгнэлт хүлээгдэж байна.
Шууд гэрээ байгуулах-1				
14	Хог тээврийн болон машин цэвэрлэгээний авто нийлүүлэх. /12 ширхэг/	-	2,096.0	З удаагийн тендер амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар ажиллаж байна.
Ажлын даалгавар батлагдах шатанд-1				
15	Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга. /Нисэхийн бус/	-	1,500.0	Тус барилгыг 21 дүгээр хороонд барихаар газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу ажлын даалгавар боловсруулсан. Батлагдах шатанд байна.
Архитектур төлөвлөлтийн даалгавар хүлээгдэж байгаа-1				
16	Цэцэрлэгийн барилга. /200 ор/ Яармагийн бус	-	2,400.0	Тус барилгыг 4 дүгээр хороонд нийслэлийн Боловсролын газарт олгогдсон 5000 м2 газарт барихаар Хот байгуулалт, хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгаврыг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021.05.28-ны өдрийн 6/741 дүгээр албан бичгээр хүссэн.
Газрын байршлыг НЭД-ын захирамжаар баталгаажуулах шатанд-3				
17	Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга	-	1,500.0	Тус барилгыг 15 дугаар хорооны нутаг дэвсгэр, "Рапид харш" орон сууцны хорооллын баруун хойд талд "Ар Ви Жи Эйч" ХХК-д биеийн тамир, спортын зориулалтаар олгогдсон газрын эзэмших эрх Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/394 дугаар захирамжаар хүчингүй болж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/297 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт олгогдсон 3700 м2 газарт барихаар болсон. Газрын гэрчилгээ гаргуулах шатанд байна.
18	Цэцэрлэгийн барилга /200 ор/	-	2,400.0	Тус цэцэрлэгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/394 дүгээр захирамжаар газар эзэмших эрх нь хүчингүй болж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/296 дугаар захирамжаар цэцэрлэгийн барилгын зориулалтаар олгогдсон "Рапид харш" хорооллын баруун хойд талын 3700 м2 газарт барихаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулахаар албан бичиг хүргүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар орохоор хүлээгдэж байна.
19	Цэцэрлэгийн барилга /200 ор/ - Нисэхийн бүм	-	2,400.0	Тус цэцэрлэгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/398 дугаар захирамжаар газар эзэмших эрх нь хүчингүй болж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/281 дүгээр захирамжаар

				Цэцэрлэгийн барилгын зориулалтаар олгогдсон "Буянт-Ухаа-1" хорооллын зүүн талын 3000 м2 газарт барихаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албандаа газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулахаар албан бичиг хүргүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаа орохоор хүлээгдэж байна.
Бусад бэлтгэл ажил хийгдэж буй-2				
20	"Эко зуслан"-ийн зураг төсөл, төсөв	-	100.0	Байршлын судалгаа хийгдэж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/107 дугаар захирамжаар 14 дүгээр хороонд 13.5 га газар олгогдсон. Газрын байгаль орчны дүгнэлт, хянан баталгаа хийлгэх шатанд байна.
21	Спортын цогцолборын зураг төсөл, төсөв	8	200.0	Газрын зориулалтыг өөрчлүүлэхээр НГЗБА-нд албан бичиг хүргүүлсэн.
ДҮН		17,830.0		

**Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний ажлын явц**

№	Төсөл, арга хэмжээний нэршил	Хороо	Төсөвт өртөг /сая.төг/	Ажлын явц
1	Камержуулалт	1-11, 14-21	730.5	Техникийн нөхцөл, техникийн тодорхойлолтыг 2021.06.15-нд Худалдан авах ажиллагааны албан хүлээлгэн өгсөн. Тендер зарлагдах шатанд.
2	Цагаан эргийн гүүрийг засварлах	12, 13	23.0	2021.06.03-нд 2 дахь тендер зарласан. 2021.07.02-нд нээлт хийнэ.

Дүүргийн гудамж, зам талбайн хусаж тэгшлэх болон хороолол доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх байршлыг Хан-Уул дүүргийн Авто зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-тэй хамтран судалсан бөгөөд 21 байршилд зам тэгшлэх, 3 байршилд хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээ хийхээр дүүргийн Засаг даргын А/282 дугаар захирамжийг батлуулж, үүний дагуу ажлын даалгаврыг батлуулсан.

Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих 30 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулсан.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Хатуу хүчилттай авто зам тавих" ажил / "4, 5 дугаар хорооны зааг Яармаг худалдааны төвийн зүүн уулзвараас хойших зам" /-ын ажил эхлүүлэх зөвшөөрлийг Эдийн засаг, төлөвлөлт, хот тохижилтын асуудал хариуцсан орлогчийн 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 06/153 дугаар албан бичгээр Улаанбаатар Хотын Ус Сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ-аас хүссэн.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр хэрэгжих камержуулалтын ажлын байршлын судалгаа хийж, техникийн тодорхойлолт боловсруулах даалгаврыг гаргуулахаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 06/336 дугаар албан бичгээр Нийслэлийн мэдээллийн технологийн газраас хүссэн.

Тайваны "Хүүхэд гэр бүлийг дэмжих сан"-ийн Монгол дах Төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй ундны ус сайжруулах төслийн хүрээнд 9, 16 дугаар хороонд худаг барих төсөл бэлтгэн хүргүүлсэн.

Дүүргийн техник хяналтын комиссын хуралдаанаар барьцаа хөрөнгө чөлөөлөх, ажил гүйцэтгэх гэрээ сунгах, ажил гүйцэтгэх үед гарсан алдаа дутагдлыг хэрхэн арилгах, техник хяналтын комисс ажиллах, гүйцэтгэл олгох зэрэг асуудлуудыг хэлэлцэж нийт 11 асуудал бүрэн шийдвэрлэж, байгууллагуудын гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл шалгах, хурлын тэмдэглэл бэлтгэх, гүйцэтгэлийн акт боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн санхүүжилтийн бичиг баримтын бүрдлийг хангулсан.


Барилгын ажил хийгдэхээр төлөвлөсөн талбайд судалгаа шинжилгээ 20 удаа хийж ажлын даалгавар гаргах бодит талбайн хэмжилт, дүнэлт гаргасан.

Дүүргийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил дээр Нийслэл дэх Төрийн аудитын газраас хяналт шалгалаа хийгдэхэд ажил шалгуулж хамтран ажилласан, бөгөөд шаардлагатай байгууллагууд руу албан мэдэгдэл өгч хугацаатай даалгаврыг биелүүлсэн.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоол, "Барилга, замын ажлыг гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/49 дүгээр тушаалыг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын А/139 дүгээр захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан хашаа хайсыг засаж сайжруулсан.



Дүүргийн хэмжээнд сэргээн засварлах шаардлагатай 16 хөшөө дурсгал, түүхэн дурсгалт газруудын судалгаа, шаардагдах төсвийн тооцоог хийн холбогдох байгууллагад хүргүүлсэн.



#### Хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн хяналт тавьж ажилласан байдал:

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Жаргалантын аманд байрлах "Хан-Уул дүүргийн ахмадын сувилал"-ын барилгын ажлыг "Голден лайт" ХХК хийж гүйцэтгэх ажил дээр захиалагчийн төлөөллөөр ажиллан Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажиллуулсан.


Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Тайны аманд байрлах “Хан-Уул дүүргийн ахмадын сувилал”-ын барилгын гадна тохижилтын ажлыг “ЖАМ” ХХК түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 60 хувьтай.



“Центр лайн констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Хан-Уул дүүргийн харьяа байгууллага, хороодын засвар”-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан.



Хан-Уул дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэрт “Дөрвөн улирлын Цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажлыг “Чингисийн отог” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.




Хан-Уул дүүргийн 2,3,9,11,14,19-р хороонд явган хүний замын тохижилтын ажлыг “Морин сувд” ХХК түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 80 хувьтай.



Хан-Уул дүүргийн 5, 16, 21-р хороонд “Хатуу хучилттай авто зам тавих” ажлыг “Хомын тал” ХХК түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 40 хувьтай.



Хан-Уул дүүргийн 9-р хороонд “Тохижилт, үерийн хамгаалалт хийх” ажлыг “СБМ” ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 80 хувьтай.



#### Дүүргүүдийн санал асуулгыг зохион байгуулсан байдал:

Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулгын SMART UB аппликашны ldf.ub.gov.mn цахим системд админ хэрэглэгчээр нийт 21 хорооны 26 Зохион байгуулагчийг хорооны эрхээр, 208 хэсгийн ахлагчийг хэсгийн эрхээр нийт 234 хүнийг бүртгэн заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Цахим системд дүүргийн 2 асуулт, 29 хариултыг болон Хан-Уул дүүргийн хэмжээнд цахим санал асуулгад оролцох боломжит нийт 90306 иргэн байна гэж тооцоолон хороо тус бүрийн судалгаанд хамрагдах боломжтой тоог оруулсан.

Цахим санал асуулгыг амжилттай явуулахад зориулан Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтын хэлтсийн үйл ажиллагааны зардалд 6.000.000 /зургаан сая төгрөг/ батлуулсан бөгөөд дараах байдлаар зарцуулахаар төсөв батлуулсан.

№	Зориулалт	Нэг бурийн үнэ	Төсөв	Хугацаа
1	Хороодын албан хаагчдад нэгж худалдан авах	20.000	3.860.000	2021.03.05
2	Хороодын дунд болзолт уралдаан зохион байгуулах	1.600.000	1.600.000	2021.04.05
3	Өргөмжлөл, дурсгалын зүйл бэлтгэх	50.000	540.000	2021.03.25
			6.000.000	

Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулгатай холбоотой сургалтыг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 17-ний хооронд хороодын Зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 12000 ширхэг иргэдэд зориулсан тараах материал, постерийг хороодод хуваарилан тараасан.

Дүүргийн [www.khanuu1.mn](http://www.khanuu1.mn) мэдээллийн сайтад Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулгад иргэдийг санал өгөхийг уриалах зорилгоор 3 удаа мэдээ бэлтгэн байршуулсан.

Мэргэжилтэн У.Намуун 3 дугаар сарын 14-ний өдрийн STAR телевизийн ярилцлагын цагт оролцон 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих ажилд иргэдээс авах цахим санал асуулгын талаар үзэгчдэд мэдээлэл өгсөн.

Орон нутгийн хөгжлийн сангийн сайн жишээг иргэдэд таниулах зорилготой телевизийн нэвтрүүлэгт 10, 13 дугаар хорооны албан хаагчдийг оролцуулсан.

ОНХС-ийн цахим санал асуулга нь 3 дугаар сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл Хан-Уул дүүргийн оролцох боломжит нийт 90308 иргэн байгаа гэж тооцоолсноос 56923 иргэн санал өгч, нийт иргэдийн 63%-ийн ирцтэй санал асуулга явагдаж дууссан. Саналын дүнг нэгтгэх ажил хийгдэж байна.

Хан-Уул дүүргийн хороодын санал асуулга зохион байгуулсан байдал:

Хороо	Санал авах	Санал өгсөн	Хувь
1	5440	4993	91.8
2	5010	1634	32.6
3	5370	4450	82.9
4	5924	4410	74.4
5	2980	3031	101.7
6	2940	1766	60.1
7	2778	851	30.6
8	5168	5256	101.7
9	3365	3397	101.0
10	3865	1638	42.4
11	6109	1237	20.2
12	3040	1992	65.5
13	2581	2589	100.3
14	2597	1860	71.6
15	7319	1295	17.7
16	5554	5025	90.5
17	4200	4238	100.9
18	2890	1005	34.8
19	4950	2533	51.2
20	5850	1898	32.4
21	2378	1825	76.7
<b>ДҮН</b>	<b>90308</b>	<b>56923</b>	<b>63.0</b>

#### **1.4 Үндэсний хөтөлбөрт заасан хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Монгол Улсын УИХ болон Засгийн Газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн 2020 оны хэрэгжилтийг хүлээн авч нэгтгэн НЭДТГ-ын ХШҮХ-т 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 06/08 дугаар албан бичгээр хүргүүлэв.

#### **ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУДААС:**

**"Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж иргэд, төрийн албан хаагчдын жендерийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

- Хан-Уул дүүргийн Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж, Жендерийн салбар хорооны гишүүдэд танилцуулсан бөгөөд дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

2. Жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах зорилгоор “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аяныг 2021 оны 03 дугаар сард хороодод өрнүүлж, цахим мэдээллийн сувгаар иргэдэд хүргэсэн. Аяны хүрээнд Жендэрийн үндэсний хорооноос 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зэрүүтэй байдлын суурь судалгааны зарим тодорхой асуудал” цахим хэлэлцүүлэгт дүүргийн Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон хороодын Хөгжлийн нийгмийн ажилтнууд оролцсон.



3. “Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх” сургалтыг 2021 оны 05 дугаар сард зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга О.Мягмарсүрэн, 9 дүгээр хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан Л.Дэлгэрмаа нар оролцож сургагч багш болсон.

### **1.5 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар батлагдсан “Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс Хан-Уул дүүрэг хариуцсан болон хамтран хэрэгжүүлж буй 4 бүлгийн 27 арга хэмжээ байна. Тус арга хэмжээний 2021 оны эхний хагас жилийн биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч, нэгтгэн 68.7 хувьтай хэрэгжсэн байна. Хэрэгжилтийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

“Нийслэлийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-ний төсөлд тусгах зорилт, төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж байна.


Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр: Гэр хорооллын айл өрхүүдийг түлшээр хангах 60 борлуулалтын цэг, З хангамжийн баазын түлш татан авалт, түгээлтэд тогтмол хяналт тавьж дүүрэг, нийслэлийн Онцгой комиссыг мэдээллээр хангаж ажилласан. 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 14-ний өдөр хүртэл хугацаанд 28590.4 тн түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг хангасан бөгөөд сайжруулсан түлшний агуулах болон борлуулалтын цэгүүдийн түлшний нөөц, борлуулалт, татан авалтад тогтмол хяналт тавьж ажилласан.



2021 оны 1, 2, 3, 4 дүгээр сард гэр хороолол бүхий хороодын нутаг дэвсгэрт түүхий нүүрсийг хориглох, сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, хэрэглээнд болон хог хаягдал, орчны бохирдолд хяналт тавих үүрэг бүхий 525 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус гэрээт ажилтнуудыг ажиллуулсан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Угаарын хийн хордлогоос

урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай" А/346 дугаар захирамжийн дагуу гэр хорооллын айл өрхүүдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөв галлагаа, угаарын хийн мэдрэгчийг ажиллуулах заавар бүхий 30000 ширхэг зөвлөмж, сээрэмжлүүлгийг тараасан. Мөн дүүрэг, хороодын цахим хуудсуудаар угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх болон зөв галлах зөвлөмжүүдийг тогтмол мэдээллэж ажилласан.


Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээ хүргэсэн байдал.



Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын хэсэг байгуулах тухай" А/1286, дүүргийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны А/31 дүгээр захирамжийн дагуу 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2020 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн бүртгэл, тооллогыг батлагдсан журмын дагуу явуулж, "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" цахим мэдээллийн системд бүртгэх ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан.

2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газартай хамтарч 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хорооны 15 зохион байгуулагчийг "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан"-г ашиглах, тоо бүртгэлийн мэдээлэл оруулах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх цахим сургалтад хамруулсан.

"Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан"-г ашиглах, тоо бүртгэлийн мэдээлэл оруулах цахим сургалт:



Дүүргийн хэмжээнд "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" цахим мэдээллийн системд ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуух бүртгэгдсэнээс сууцны төрлөөр нь авч үзвэл 42.4 хувь буюу 5319 нь гэрт, 57.6 хувь буюу 7233 нь байшинд ашиглагдаж байна. Мөн нийт бүртгэгдсэн ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуух хэрэглэгч өрхийн 39.1 хувь буюу 4906 нь сайжруулсан, 60.9 хувь буюу 7646 нь ердийн зуух ашиглаж байна.

График 1. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл, /3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуух.



Улсын төсвийн хөрөнгө 1.4 тэрбум төгрөгийн оруулалтаар Туул голын сав дагуух 1000 өрхөд стандартын шаардлага хангасан нүхэн жорлон нэвтрүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 12 дугаар хорооны 850 өрхийн хашаанд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг суурилуулж, хөрний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай 485 өрхийн судалгааг гаргаж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албандаа хүргүүлсэн.

Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж суурилуулах ажлын явц.



Ариутгал, халдвартгуйжүүлэлт:

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд Ковид 19 суурин болон явуулын шинжилгээний цэгүүд, 1, 2, 3, 4, 6, 10, 11, 12, 13, 14, 15, 17, 19, 20 дугаар хорооны тусгаарлалтад авсан байрууд, эрсдэлтэй цэгүүд зэрэг эрсдэлтэй газруудад нийт 349444.2 м.кв талбайг "Технологийн инкубатор" ХХК, "Улаанбаатар ариутгал" ХХК, "Сан хими" ХХК, "Сайн тушиг" ХХК ариутгаж халдвартгуйжүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн A/265 дугаар захирамж, нийслэл, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн чиглэлийн дагуу халдвартын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 4 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл хугацаанд 21 хорооны 270 хүүхдийн тоглоомын талбайг ариутгаж халдвартгуйжүүлсэн.

Хүүхдийн тоглоомын талбайг ариутгаж халдвартгуйжүүлэх ажлын явц:



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч тусгай зориулалтын мананцар үүсгэгч 7 автомашинаар дүүргийн 1-21 хорооны орон сууц, гэр хороолол, иргэд олноор цугладаг хэсгүүд, автобусны буудал, зах, дэлгүүр, худалдааны төвүүд, эмнэлэг, цэцэрлэгт хүрээлэн, хөл бөмбөгийн талбай зэрэг газруудыг 7 удаагийн давтамжтай ариутгаж халдвартайжжүүлсэн.

Мананцар үүсгэгч машинаар ариутгаж, халдвартайжжүүлэх ажлын явц:



Хөрсний бохирдлыг бууруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэр хорооллын 13855 нүхэн жорлон, 8340 бохирын цооног, шинжилгээ авах, вакцинуулалт хийх суурин болон явуулын цэгүүд, тусгаарлалтад авсан байрууд болон бусад эрсдэлтэй газруудад коронавируст халдвартын үед голомтод эцсийн болон урьдчилан сэргийлэх чиглэлээр 400,000 м.кв талбайд ариутгал халдвартайжжүүлэлт хийх захирамж, ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Тендер шалгаруулах шатанд байна.

Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Хотын соёлд суралцах болон хотын хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулсан. Мөн нутгийн захирагааны 2 байгууллага, 21 хороо, дүүргийн хэмжээнд нийт 24 байгууллагын Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулсан бөгөөд цаашид дээрх зөвлөлүүдтэй хамтран “Хотын соёл Хан-Уул дүүргэс” олон нийтийн аяныг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 2 баг шалгаруулж, тус бүр 10 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн бөгөөд тус хөтөлбөрт хамрагдах хүснэгтэй залуусын төслийг хүлээн авч байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг тус тус баталсан. Тус хөтөлбөрүүдийн мэдээллийг иргэдэд видео хэлбэрээр болон Nap-Uul.hudulmur-halamj.gov.mn, Khanuuil.mn сайтууд, Хан-Уул дүүрэг, Хөдөлмөр халамж фэйсбууц хуудас, Хан-Уул дүүргийн Хөдөлмөр халамжийн

үйлчилгээний хэлтэс цахим хуудас, 20 хорооны мэдээллийн самбарт тус тус байршуулан үйлчилгээ аваад шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг байршуулсан.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулах чиглэлээр:

1. Коронавирусийн халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн газрын тогтоол, улс, нийслэл, дүүргийн онцгой комиссын шийдвэрийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосны улмаас хүүхдийн эрх зөрчигдхөөс урьдчилан сэргийлсэн видео, контентуудыг дүүрэг, хорооны албан ёсны цахим хуудас, пейж хуудсанд байршуулж сурталчлан ажилласан.

2. Олон улсын гэр бүлийн өдрийн хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ” сургалт, хэлэлцүүлгийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран цахим орчинд зохион байгуулж, 2500 иргэнд мэдээлэл хүргэсэн.



3. “Шилдэг гэр бүл”-ийг шалгаруулах удирдамжийг батлуулан 21 хорооны Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан.

БЗДХ/ДОХ, халдварт гепатит, бусад халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулах чиглэлээр:

1. Сүрьеэз илрүүлэх идэвхтэй үзлэгт хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын судалгааг;
  - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настны асрах байгууллага
  - ✓ Хүүхдийн төрөлжсөн асрамж, хalamжийн төвүүд
  - ✓ Үйлдвэрийн газрууд, оёдлын үйлдвэрүүд
  - ✓ Радио, телевизийн байгууллагууд
  - ✓ Арилжааны банкнууд
  - ✓ Оюутны байрууд гэсэн төрлөөр авч нийт 163 байгууллагын судалгааг нэгтгэн дүүргийн Эрүүл мэндийн төвд хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтэс, Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний хэлтэс, Улаан загалмайн хороо хамтран дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлж, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг тус дүүргийн 14 дүгээр хороонд байрлах “Өлзийт асар” ТББ-ын байранд зохион байгуулсан.

Тус үйл ажиллагаагаар орон гэргүй, тэнэмэл амьдралаар амьдардаг, архины хамааралтай нийт 72 иргэнийг бүртгэж, судалгаа авч, мэдээлийн санг шинэчлэн, иргэдийг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулсан.



**1.6 Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Дүүргийн ИТХ-ын 2020 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эрүүл-Эко дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 9 хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/09 дүгээр захирамжаар байгуулж, хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/322 дугаар захирамжаар тус тус боловсруулан батлуулж, хэрэгжилтийн хангулан ажиллаж байна.

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв
1.7	1 “Хорооны хөгжил” дэд хөтөлбөр	117,000,000
	2 “Архигүй орчин” дэд хөтөлбөр	43,000,000
	3 “Ахмадаа дээдэль” хөтөлбөр	140,000,000
	4 “Эрүүл дүүрэг” хөтөлбөр	75,000,000
	5 “Залуучуудын хөгжил” хөтөлбөр	50,000,000
	6 “Багш” хөтөлбөр	105,000,000
	7 “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” хөтөлбөр	170,000,000
	8 “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөр	200,000,000
	9 “Хогтуй Хан-Уул” дэд хөтөлбөр	100,000,000

**Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулан Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөр нь 5 бүлэг, 23 дэд бүлэг, 102 арга хэмжээтэй, хөтөлбөрийн хүрээнд 9 дэд хөтөлбөр хэрэгжихээр батлагдсан. Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч, нэгтгэн боловсруулж байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудаас:

Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Туул тосгоны шинээр ашиглалтад орсон эмнэлэгт коронавируст халдвараар өвчилсөн иргэдийг эмчлэх зорилгоор 100 ор нэмж дэлгэх ажлын хүрээнд тус эмнэлэгт шаардлагатай ор болон бусад бараа материалыг нийлүүлэхээр 12,177,000 төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.



Хичээлийн жил тутам боловсролын салбарын 170 гаруй нэгж байгууллагаар зөвлөн туслах, хяналт шалгалтын ажлаар ажлын хэсэг болон хэлтсийн дарга, мэргэжилтнүүд газар дээр нь ажилладаг тул төрөөс боловсролын талаар баримтлаж буй бодлого, хэлтсийн чиг үүргийг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор “Боловсролд ээлтэй Хан-Уул” төслийг хэрэгжүүлж, хөтөлбөрөөс 38,000,000 төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.

Хамгаалалын үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдийг сургууль завсардуулахгүй байх үүднээс хичээл сургуульд хүргэж өгөх, авах, насанд хүрсэн болон гэрч, хохирогч хүүхдүүдийг нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, шүүх, цагдаагийн байгууллагад тайлбар мэдүүлэг өгөх, шүүх хуралд оролцуулах, төрийн бус байгууллагуудаас үйлчигээ авах үйлчилүүлэгч бүрийн кейсд тохирсон мэргэшсэн үйлчилгээнд хамруулахад шаардлагатай автомашин худалдан авах төслийг хэрэгжүүлж, 35,000,000 төгрөгийн санхүүжилтийг хөтөлбөрөөс олгохоор шийдвэрлэсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажилгааны хөтөлбөрт тусгагдсан “Ахмадаа дээдэль” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлд дараах төслүүдийг ирүүлээд байна.

- ✓ “Эко ахмадын сувилал” ОНӨААТҮГ-“Барилгын тохижилт засал чимэглэлийн төсөл” /40,000,000 төгрөг/
- ✓ Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны “Ахмадын зөвлөл”-“Дөрвөн бэрхээр зуут хаях” тоглоом заах сургалт зохион байгуулах төсөл /2,000,000 төгрөг/

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд:

“Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “АПУ” ХК нь тус дүүргийн 21 хорооны 63 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүнсний тусламж үзүүлсэн. Мөн тус дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гараар урласан 990 ширхэг арьсан цүнхийг тус бүрийг 12,000 төгрөгөөр худалдан авч, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн.



“Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулцгаа” удирдамжийн хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд жирэмслэлтээс сэргийлэх арга болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар 2021 оны 04 дугээр сарын 08-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан 35 эмэгтэйг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан.



Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ийг нэвтрүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй, чанартай хүргэх зорилгоор нийгмийн халамжийн 11 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд /ehalamj.mn/ системээр нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.



Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас нийт 33651 иргэнд 5144.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: Жирэмсэн эхийн тэтгэмж 2934

иргэнд 273.3 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 18 иргэнд 27.0 сая төгрөг, 0-3 хүртэлх насын хүүхдээ асарч буй эхийн тэтгэмж 10626 иргэнд 1885.9 сая төгрөг, Өрх толгойлсон эх /эцэг/-т олгох тэтгэмж 277 иргэнд 115.8 сая төгрөг, Эхийн алдар одон 9640 иргэнд 1190.5 сая төгрөг, Насны хишиг 8507 иргэнд 709.4 сая төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэвэр 1649 иргэнд 942.7 сая төгрөгийг тус тус олгосон байна.

- **Тохиижилтын ажлын чиглэлээр:**

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/98 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт “Манай хороо – Миний гудамж” аяныг зохион байгуулах 34 хүний бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулагдаж, холбогдох хэлтэс, албадын саналыг авч, аяны төлөвлөгөө удиরдамжийг батлан, хэрэгжилтийг ханган, тайлан мэдээг сар бүр гаргаж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад тайлагнаж ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/243, дүүргийн Засаг даргын 2021 оны А/244 дүгээр захирамжийн дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг 2021 ны 05 дугаар сарын 15-27-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 3 ерөнхий боловсролын сургууль, 17 цэцэрлэг, эмнэлэг, Эко ахмадын сувилал, орон сууцны хорооллуудад 1968 ширхэг, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд 6170 ширхэг мод, бут, сөөгийг тарьсан.



Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран зохион байгуулсан “Өрх бүр хашаандaa мод тарья” арга хэмжээний хүрээнд 13 хорооны 464 айл өрхөд нийт 3250 ширхэг мод, бут, сөөгний суулгац, дүүргийн Засаг даргын Тамгын газраас 10, 16 дугаар хорооны 100 айл өрхтэй хамтарч 750 ширхэг чацаргана, 250 ширхэг үхрийн нүдний суулгацыг тарьсан.

**“Өрх бүр хашаандaa мод тарья” арга хэмжээ**



Дүүргийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/58 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж, талбайг цэцэгжүүлэх, тохижуулах болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хун цэцэг, хилэн цэцэг, чимэглэлийн байцаа цэцэг, эрвээхэй цэцэг, астро цэцэг, зэрэг гоёл чимэглэлийн 525,000 ширхэг цэцгийн үрсэлгээг бойжуулах, цэцгийн мандал байгуулах ажлыг хэрэгжүүлж байна.

Тус ажлын хүрээнд 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийтийн эзэмшлийн гудамж талбайн 17 байршил, 21 хорооны гадна талбайд цэцгийн мандлыг байгуулахаар төлөвлөсөн бөгөөд өнөөдрийн байдлаар 28 байршилд 110,000 ширхэг цэцгийг тарьж суулгасан.

**Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд цэцгийн мандал байгуулах ажлын явц**



Аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын


эрэг дагуу 110 га талбайд ахмадын чөлөөт цаг өнгөрөөх хэсэг, волейболын талбай, сагсан бөмбөгийн талбай, цэцгийн мандал, цөөрмийн эргийн тавцан, хүүхдийн тоглоомын талбай, турван хэсэгт голын эргийн тавцан, алсыг харах цамхаг, шинээр тарьсан ховор ургамлуудын хэсэг, түр амрах хэсгүүд бүхий Мишээл байгаль орчин, танин мэдэхүйн ботаник хүрээлэнг байгуулсан.

**Мишээл танин мэдэхүйн цэцэрлэгт хүрээлэн**



Дүүргийн хэмжээнд 2625 ширхэг модыг хэлбэржүүлэх, мөн 14 хоногийн давтамжтайгаар  $326 \text{ m}^2$  ургамлан хашлага,  $942 \text{ m}^2$  бут сөөг,  $9700 \text{ m}^2$  зүлэгт талбайг хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Мод, бут, сөөгийг хэлбэржүүлэх ажлын явц**



“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хариуцсан талбайн ногоон байгууламжаа өдөр бүр усалж, хог хаягдлын цэвэрлэгээ үйлчилгээг тогмол гүйцэтгэж ажиллаж байна. 2021 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 4 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд 515 ширхэг модыг хортон шавжнаас хамгаалах үүднээс шохойдох ажлыг гүйцэтгэсэн.

*Ногоон байгууламжийн арчилгаа, усалгааны ажлын явц*



Хог хаягдлын чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хетэлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хоггүй Хан-Уул” дэд хетэлбөрийг боловсруулж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжийн дагуу “Хоггүй Хан-Уул 2021” аяны хүрээнд зохион байгуулсан 3 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 1787 аж ахуйн нэгж байгууллага, 192 сууц өмчлөгчдийн холбооны 12368 ажилтан албан хаагч, иргэд оролцож 221724 м<sup>2</sup> талбайгаас 428,6 тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

*“Хоггүй Хан-Уул 2021” аяны хүрээнд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний ажлын явц*



Дүүргийн хэмжээнд хог хаягдлын тээвэрлэлт, цэвэрлэгээ, үйлчилгээнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ, “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ, “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийт 71851 тн хог хаягдлыг 17885 рейсээр ачиж тээвэрлэсэн байна.

**Хог тээвэрлэлтийн явц**

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлтэй хамтарч “Хогоо ангилдаг СӨХ” болзолт уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд Хан Уул дүүргийн Сууц өмчлөгчдийн холбоод амжилттай оролцож 8 СӨХ шагналт байранд шалгарсан. Тэргүүн байранд дүүргийн 4 хорооны Шинэ Өргөө СӨХ шалгарсан.

**“Хогоо ангилдаг СӨХ” болзолт уралдааны ажлын явц****Гэрэлтүүлэг, хаяг реклам, дэд бүтцийн чиглэлээр:**

Хан-Уул дүүргийн Засаг Даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/282 дугаар захирамжийн дагуу 7, 8, 10, 16 дугаар хорооны 13 байршилд зам талбайг хусаж тэгшилж, дайргаар засварлах, 1, 15, 17, 18, 19 дүгээр хорооны 17 байршилд авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрийн 15 байршилд 2170 м<sup>2</sup> авто замын нэхсэн.

**Авто замын нөхөөс хийж буй ажлын явц**

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд хэрэгжих “Хатуу хучилттай авто зам тавих” ажлын гүйцэтгэгчээр “Хомын тал” ХХК ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 5, 16, 21-р хороодод нийт 3.2 км авто зам тавигдах бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 5 дугаар хороо Яармагийн замын цахилгаан, дулаан, холбооны ажил болон авто замын хашлага, 16 дугаар хороо, дулаан шугам хүчитгэх ажил, хөрс хуулалт, 21 дүгээр хороо хөрс хуулалт, ухмалын ажил хийгдсэн, хашлага хийгдэж байна.

**Авто замын барилгын ажлын явц**

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 12 дугаар хороо Малчны хэсэгт 45 ширхэг гэрэлтүүлэг шинээр хийгдэж, ашиглалтад оруулсан. Дүүргийн гэр хороолол болон орон сууцны гэрэлтүүлгийн сайжруулах ажлын хүрээнд говийн зам дагуух 48 натри гэрлийг 100 вт лед гэрэл болгон шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

**12 дугаар хороо, Малчны хэсгийн гэрэлтүүлгийн ажлын явц****Байгаль орчны чиглэлээр:**

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1034, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/125 дугаар захирамжаар 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох, тээвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын ачааны авто тээврийн хэрэгслийн бүх жинг Нисэхийн аюулгүйн тойргоос Биокомбинат /12 дугаар хороо/, Шувуун фабрик /13 дугаар хороо/ Өлзийт /14 дүгээр хороо/ хүртэл замд “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011 стандартад заасны дагуу хязгаарлаж, тээвэрлэлт хийх хугацааг өглөөний 08:00 цагаас оройны 22:00 цаг хүртэл байхаар тогтоож, хэрэгжилтийг ханггуулж ажиллаж байна.

2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Замын цагдаагийн хэлтэс “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011 стандартыг мөрдүүлэх зорилгоор том оврын ачааны тээврийн хэрэгслийн даацыг шалгах явуулын хэмжих төхөөрөмж /пүү/ ажиллуулж эхэлсэн бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар даац хэтрүүлсэн 82 тээврийн хэрэгсэлд арга хэмжээ тооцож ажилласан. Хяналт шалгалтын ажил 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл үргэлжилнэ.

**Түгээмэл тархацтай ашигт малтмал тээвэрлэлтэд хяналт тавьж буй ажлын явц**

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах зорилгоор дүүрэг Мэргэжлийн хяналтын хэлтэс, Мал эмнэлгийн тасагтай хамтран мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж 2020 оны ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж, зөрчил дутагдлыг арилгуулж 2021 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан.

Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мал, амьтны 280 гаруй сэг зэмийг Хан-Эко тээвэр ОНӨААТҮГ-ын захирагаатай хамтран хогийн цэгт устгаж, малын хашаа саравч, етег бууц тэжээлийн агуулах, түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг, худаг уст цэг зоорь агуулах бүхий нийт 226 объектын 36780 мкв талбайг ариутгаж халдвартгүйжүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээ буюу халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт 50.5%-тай явагдсан.



Дүүрэгт 2021-2024 онд хэрэгжих "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан хүнсний ногооны тариалалтыг дэмжих ажлын хүрээнд хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үр хөнгөлөлттэй авах ногоочдын хүсэлтийн дагуу бөөрөнхий сонгино 0,5 тн, шар луувангийн үр 5 кг, шар манжин 1 кг, хүрэн манжин 2 кг, урт сонгино 15 кг, сармис 40 кг, бууцай 2 кг, тарвас 0,1 кг, хүлэмжийн хэмх 300ш, чинжүү 1 кг үрийг 4 аж ахуйн нэгж 167 иргэнд хөнгөлөлттэй үнээр олгож, тариалалтыг дэмжин ажилласан. Мөн Хөдөө аж ахуйн дэмжих сангаас хөнгөлөлттэй үнээр олгох хүлэмжийн зээлэнд 4 иргэнийг дэмжиж тодорхойлсон.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2 дугаар байрны 1 давхарт байрлах 2 өрөө 32м2 өрөөнд "Бойжуулах төв"-д 12 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй ажлын байраар ханганд, дэмжин ажилласан.

**Иргэд, ёсвер үе, залуучуудыг согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршилаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх чиглэлээр:**



Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-нд баталсан "Нийслэлийн Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зэрчлэөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжийг сурталчлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн ИТХ-тай хамтран Хүүхдийн эрхийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нелөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн цахим сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж Ерөнхий боловсролын 10, 15 дугаар сургуулийн ахлах ангийн 101 сурагчдыг хамруулсан.

Мөн дүүргийн Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэстэй хамтран "Архинаас татгалзъя" сэдэвт сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Архи согтууруулах ундаа хэрэглэж эрүүлжүүлэх байранд saatuuлагдсан 15 иргэнийг хамруулсан.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**2.1 Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн уурэг, даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:**

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 23 тогтоол шийдвэрийн 69 заалтыг хяналтад авч, дэргэдэх хэлтэс, албад руу 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 04/799 дүгээр албан бичгээр хургуулсэн. Биелэлтийг Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албадаас авч нэгтгэн, холбогдох албан тушаалтанд танилцуулсан.

Мөн нийслэлийн Засаг даргын 13 захирамжийн 31 заалт, нийслэлийн Засаг даргын 1 албан даалгаврын 8 заалт, нийслэлийн Засаг даргын 5 хуралдааны тэмдэглэлийн 11 заалт нийт 19 тогтоол шийдвэрийн 50 заалтын биелэлтийн дундаж 86.5%-тай хэрэгжсэн байна.

2020 оны эхний хагас жилд тайлагнах 4 тогтоол шийдвэрийн холбогдох 41 заалтуудыг хяналтад авч, биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг болон Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, албадаас нэтгэн, батлуулж 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 04/846 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. /Биелэлтийн дундаж-67.5%/

	ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ	ҮНЭЛГЭЭ
2021 оны эхний хагас жилийн байдлаар				
Монгол Улсын хууль	4	29	85.1%	
Улсын Их Хурлын тогтоол	1	1	70%	
Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	50%	
Засгийн газрын тогтоол	1	9	76.6%	
ДҮН	7	41	70.4%	

**Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 217, 218 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан, сар, хагас жилийн үйл ажиллагааны тайланг тус тус нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтад танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тус тус тайлант хугацаанд нь <https://erp.ulaanbaatar.mn/> цахим сайт болон албан бичгээр хургуулсэн.

**Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, батлуулах чиглэлээр;**

Төсвийн Шууд захирагчийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгах саналыг хэлтэс, тасгудаас хүлээн авч нэгтгэн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр батлуулсан. Тус төлөвлөгөө нь нийт 6 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд нэгдүгээр хэсэг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 17 зорилт, 21 арга хэмжээ, хоёрдугаар хэсэг Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 5 зорилт, 5 арга хэмжээ, гуравдугаар хэсэг Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 13 зорилт, 15 арга хэмжээ, дөрөвдүгээр хэсэг дүүргийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт арга хэмжээнд 30 зорилт, 44 арга хэмжээ, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 1 зорилт, 43 арга хэмжээ, Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 1 зорилт, 16 арга хэмжээ, нийт 67 зорилт 144, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эхний хагас жилийн

байдлаар 67 зорилтын биелэлт 54.25 хувьтай, 144 арга хэмжээний биелэлт 55.7 хувьтай тус тус хэрэгжсэн бөгөөд гүйцэтгэлийн тайланг дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 04/873 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.

Хүснэгт-1

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ  
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Бодлогын баримт бичиг	Зорилтын тоо	Хувь	Арга хэмжээний тоо	Хувь
1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	17	61,6%	21	53%
2	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд	5	58%	5	58%
3	Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд	13	43%	15	48.3%
4	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд	30	40.5%	44	49.5%
5	Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж байгууллагын дүрмээр хүлээсэн чиг уургийг хэрэгжүүлэх хүрээнд	1	45%	43	48.4%
6	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	1	77.4%	16	77.4%
7	Нийт	67	54.25%	144	55.7%

Засаг даргын Тамгын газрын нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, үнэлж, дүгнүүлэх ажлыг зохион байгуулсан талаар:

Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх “Үнэлгээний баг”-ийн бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлуулан, Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, тасаг, албадын 67, хороодын 51 нийт 118 албан хаагчийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7.8 дугаар хавсралтаар батлагдсан загвар, аргачлалын дагуу хүлээн авсан. Үүнээс албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах нийтлэг үүргээ хангалтгүй гүйцэтгэн, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хангалтгүй биелүүлэн “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагч, шинээр томилогдсон 7, жирэмсний ээлжийн амралтаявч орж ирсэн 2, нийт 10 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг олгоогүй. Бусад 108 албан хаагчдад Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Б/173 дугаар тушаалаар урамшууллыг холбогдох журмын дагуу олгосон.

Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны Үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тайлагнаж үнэлүүлэх чиглэлээр:

“Нийслэлийн Засаг дарга болон Хан-Уул дүүргийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-г үндэслэсэн дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын 2021 онд хэрэгжүүлэх үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулсан. Дээрх гэрээ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, “Нийслэлийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”, “Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх Эко-Эрүүл дүүрэг үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, ажил, үйлчилгээг тодорхойлоход ашигласан тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнахад тавигдах шаардлага, гэрээг дүгнэхтэй холбогдох харилцааг зохицуулахаар боловсруулагдсан. Гэрээний эхний хагас жилийн хэрэгжилт 54 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Хяналт шалгалт зохион байгуулсан талаар:


2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, давхардсан тоогоор 5342 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, зөрчлийг тухай бүр арилгуулж ажилласан. Үүнд:

- Халдварт хамгааллын дэглэм, тусгай нөхцөл шаардлага мөрдүүлэх- 16 удаа давхардсан тоогоор 4580 иргэн, аж ахуйн нэгж
- Жижиглэн худалдаа, хоол үйлдвэрлэлийн газарт тавигдах ерөнхий шалгалт – 5 удаа 542 иргэн, аж ахуйн нэгж
- Цагийн хязгаарын хэрэгжилт - 2 удаа 46 аж ахуйн нэгж
- Махны чанар аюулгүй байдалд – 4 удаа давхардсан тоогоор 174 газарт холбогдох хэлтэс албадтай хамтран хяналт шалгалт хийсэн.



Засгийн газрын 2021 оны “Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 110 дугаар тогтоолын дагуу 210 малчин өрхийг 100.000 төгрөгийн буцалтгүй тусlamжинд хамруулсан.

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй бай чиглэлээр Наадамчдын зам гудамж, Нисэхийн зам, Морингийн зам, Богдхан уулын зам, Туул гол дагуу 6 хүнийг дүүргийн Хедөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс цалинжуулан эргүүл жижүүрээр ажиллуулж, хориглсон бүсэд ихээр орж ирдэг адууны им тамга, зүс бүхий зурагжуулсан судалгааг гаргасан.



## **2.2 Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажилтай холбоотой мэдээлэл:**

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/177 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/49 дүгээр тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын А/139 дугаар захирамжийн дагуу дэд ажлын хэсэг байгуулагдаж, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн барилга угсралтын талбайн түр хашааг стандарт норм, дүрэмд нийцүүлэх, нэгж талбараасаа илүү талбайг хашаалсан хашаа хайсыг татуулах, нийтийн эзэмшлийг гудамж, зам талбай дахь орц, гарц, явган хүний замыг хааж, хөдөлгөөнд саад учруулж буй байршилуудын зөрчлийг арилгах мөн ил задгай кабелийн болон цахилгааны утасны аюулгүй байдлыг хангуулах зөрчлийг арилгах, өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн самбаруудыг цэгцлэх, стандарт норм, дүрмийг мөрдүүлэх ажлуудыг газар дээр нь ажиллаж зөрчлийг арилгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Дээрх ажлын хүрээнд:

1. Хан-Уул дүүргийн хэмжээнд барилга угсралтын талбайн түр хашааны стандартыг хангуулах шаардлагатай нийт 133 түр хашаа байгаагаас 93 байршилд стандартад нийцүүлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай хугацаатай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн ба үүнээс 12 барилгын түр хашааг шинэчлүүлсэн.
2. Нэгж талбараасаа илүү талбайг хашаалсан хашаа, хайсыг татуулах шаардлагатай урьдчилсан байдааар 29 байршил байгаагааг зөрчлөө арилгах тухай хугацаатай мэдэгдэл хүргүүлэн сонсох ажиллагаа явуулан байна.
3. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай дахь орц гарц, явган хүний замыг хааж, хөдөлгөөнд саад учруулж байгаа нийт 10 байршилд зөрчлийг арилгуулан, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлүүлсэн.
4. Ил задгай кабелийн болон цахилгааны утасны аюулгүй байдлыг хангуулахаар илэрсэн 78 байршилыг газар дээр нь цэгцэлж, янзлан аюулгүй байдлыг хангуулсан.
5. Өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн самбар, хаалт, хашлагуудыг цэгцлэх шаардлагатай 82 зөрчлийг арилган, цэгцлүүлсэн.
6. Стандартын шаардлага хангахгүй, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэл учруулахуйц нөхцөл байдал үүссэн хүүхдийн тоглоомын 77 талбай байгаагаас нийт 7 засч сайжруулж, эрсдлийг арилгасан.
7. Нийт орчны аюулгүй байдал алдагдсан 409 зөрчил байгаагаас 122 байршилд зөрчлөө арилгах тухай хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлж, 189 байршилд зөрчлийг арилгуулан ажилласан.

*Барилгын түр хашааны стандартыг хангуулах, орчны аюулгүй байдлыг хангах ажлын явц*



Аж ахуйн нэгж байгууллагын өнгө үзэмжгүй хашаа хайсыг буулгах, угааж арчлах, явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй ТҮЦ, сүүдрэвч самбар шон гадас зэргийг авах ажлын хүрээнд зөвшөөрөлгүй болон хүний хөдөлгөөнд саад учруулж буй 6 ТҮЦ, орц, гарц хаасан 6 хашаа, 10 байршилд шон, гадас, хаалт, хашлага зэргийг буулгаж чөлөөлж ажиллаа.

*Орц, гарц чөлөөлөх арга хэмжээний ажлын явц*



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн А/05 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2021 оны А/19 дугаар захирамжаар Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулсан. Хяналт шалгалтад нийт 171 СӨХ хамрагдснаас ажил сайжруулах шаардлагатай 29 СӨХ, хангалтгүй үнэлгээ авсан 5 СӨХ, бүрэн хангалттай үнэлгээ авсан 150 СӨХ байна. Тус ажлын хүрээнд Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл мэдээллийг шинэчлэн дүүрэг, хороодын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 171 СӨХ-той гуравласан гэрээг байгуулж ажилласан.

*Сууц өмчлөгчдийн холбоодын түвшин тогтоох шалгалтын ажлын явц.*



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/22 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2021 оны А/54 дугаар захирамжаар Коронавирус халдвартын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үлгэр жишээ хэрэгжүүлсэн сууц өмчлөгчдийн холбоог шалгаруулах болзолт уралдааныг зохион байгуулсан. Болзолт уралдаанд идэвхитэй оролцсон 17 СӨХ-г нийслэл, дүүргийн Засаг даргын өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр урамшуулсан.

*Ажлын явц*



Нийслэл дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг чиглэлийн дагуу эвдрэлтэй тоглоомын талбайг засварлаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 270 байршилд 794 тоглоом эвдрэлтэй байна. 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 7 байршилд 12 тоглоомыг засварласан байна.

*Хүүхдийн тоогоомын талбайг засварлаж, аюулгүй  
байдлыг хангуулах ажлын яец*



#### ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

**3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:**


**Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**

Засаг даргын Зөвлөлийн зөвлөлийн хурал: 2021 оны эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Зөвлөлийн хурал 20 удаа хуралдаж 75 асуудал хэлэлцэн, 53 үүрэг даалгавар өгөгдсөн нь 70 хувийн хэрэгжилттэй байна.



Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2021 оны эхний хагас жилийн байдлаар 23 удаа зохион байгуулагдан, нийт 173 үүрэг даалгавар өгөгдж, 87.8%-тай хэрэгжсэн. Биелэлтийг 7 хоног тутам хугацаанд нь <https://backend.ulaanbaatar.mn/> програмд тайлагнаж байна.



**Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн:**

Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг журмын дагуу 3 удаа цахимаар зохион байгуулсан. Тус зөвлөгөөнөөс дүүргийн Засаг даргын өгсөн нийт 35 үүрэг даалгавар 86.6%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгавар болон биелэлтийг <http://www.khanuu.mn/> сайтад тухай бүр байршуулж байна.

## **Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн:**

Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар 9 удаа зохион байгуулж, 89 үүрэг даалгавар өгөгдсөн нь 90,3% хувьтай хэрэгжсэн.

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн ажил:

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд ажиллах албан хаагчдын хуваарийг өдөр бүр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, Онцгой байдлын хэлтэст хүргүүлсэн.

Хан-Уул дүүрэгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/05 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээг зохион байгуулах, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг Засаг даргын Тамгын газрын нийт 43 төрийн захиргааны албан хаагчаас ажлын байрны шинжилгээний асуулга, ярилцлага авч ажлын байрны шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу хэрэгжүүлэх 8 арга хэмжээний төлөвлөгөө батлуулан, 2021 оны эхний хагас жилийн биелэлтийг нэгтгэн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 04/507 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хургуулсэн.

2021 онд дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн биелэлтийг гарган, холбогдох албан тушаалтад танилцуулсан.

## Хүуль эрх зүйн чиглэлээр:

"2021 онд хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг" дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хороод, дэргэдэх хэлтэс, алба, тасгийн албан хаагчид болон Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, иргэдэд шинэчилсэн найруулга орсон хуулиудыг сурталчлан таниулах сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран тус тус зохион байгуулсан. Үүнд:

Удирдлагын академитай хамтран "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга" сэдэвт цахим сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын нийт 163 албан хаагчийг хамруулсан.



#### Төрийн албаны зөвлөлтэй хамтран

"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн талаарх цахим сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж Засаг даргын Тамгын газар, хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын нийт 100 албан хаагчийг хамруулсан.



Олон Улсын Хүний эрхийн төвтэй хамтран "Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлт"-ийн талаарх цахим сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын 30 албан хаагч хамрагдсан.

ЗДТГ-ын Хууль зүйн тасгаас дүүргийн Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн ахлах ангийн сургчдад "Хүүхэд хамгааллын тухай хууль", "Нийгмийн халамжийн тухай ойлголт" сэдэвт цахим сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж 60 сургчийг хамруулсан.

Мөн дараах гарын авлагыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хороод, дэргэдэх хэлтэс, албадад хүргүүлсэн. Үүнд:

- Үндсэн хууль 30 ширхэг
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулаг – 130 ширхэг
- Төрийн албаны тухай хууль – 50 ширхэг
- Улаанбаатар хотод шилжин ирэгсдэд зориулсан гарын авлага – 150 ширхэг

Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянах чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 321 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын батлан гаргасан 222 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж ажилласан. Засаг даргын батлан гаргасан 120 захирамжлалын баримтыг [www.khanuuil.mn](http://www.khanuuil.mn) системд оруулж цахим хэлбэрт шилжүүлсэн.

Шүүхэд төлөөлөх, хууль хяналтын байгууллагатай харилцах:

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 5, давж заалдах шатны шүүхийн 3, дээд шатны шүүхийн 1 нийт 9 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож:

- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж гэрээ байгуулахыг даалгасан 2,
- Оролцогчийн хүсэлт болон нэмэлт нотлох баримтыг цуглуулахаар шүүх хуралдааныг хойшлуулсан 4,

- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 3 тус тус хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож ажилласан.

Захиргааны хэргийн шүүхээс 5 нэхэмжлэл хүлээн авч тайлбар болон нотлох баримтыг хүргүүлсэн.

Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж дүүргийн нутаг дэвсгэрт хууль бусаар худалдан борлуулсан эд зүйлийг Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсээс албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах зөвлөлд ирүүлсэн саналыг үндэслэн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр устгах 1 тогтоолыг батлуулан холбогдох комисст шилжүүлсэн.

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр:

Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, тасгаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан **160** гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, бүртгэлжүүлсэн байна.

Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг **5** аж ахуй нэгж, байгууллагын захиргаа, үйлдвэрчний звлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээг хянан бүртгэлжүүлсэн.

**Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:**

**Гадаадын зочид төлөөлөгчидтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааны хүрээнд санал хүргүүлж, хоёр талын хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд:**

Нийслэлийн Онцгой Комиссын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн шийдвэрээр Монгол Улс 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн улсын хилээ нээхээр болсон. Үүнтэй холбогдуулан Хан-Уул дүүрэгтэй гадаад хамтын ажиллагаатай 11 улс орнуудад хамтын ажиллагааг сэргээх, өргөжүүлэх талаар харилцан албан айлчлал хийх хүсэлт хүргүүлсэн.

Хан-Уул дүүрэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Гуанжин дүүрэгтэй хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр 04/190 тоот албан бичиг явуулсан. Тус албан бичгийн хариу 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр ирсэн бөгөөд дэлхий дахинд нүүрлэж буй Ковид-19 цар тахлыг амжилттай даван туулсны дараагаар хоёр талын хамтын ажиллагааг идэвхжүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлсэн.

Хан-Уул дүүрэг болон Болгар Улсын Изгрев дүүрэгтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр 04/182 тоот албан бичиг явуулсан. Тус албан бичгийн хариуг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан.

Хан-Уул дүүргийн зүгээс Бүгд Найрамдах Солонгос Улсын Умард Кёнгсан мужтай хамтын ажиллагаа эхлүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлсэн 2021 оны 06 дугаар сарын 07-ны 04/328 тоот албан бичгийг Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайд Н.Эрдэнэтүяд, 04/330 тоот албан бичгийг Гадаад харилцааны Яамны ази, номхон далайн орнуудын газрын захиралд хүргүүлсэн.

**Гадаад, дотоодын байгууллагуудтай гэрээ, санамж бичиг байгуулах ажлын хүрээнд:**

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон "Юнител" ХХК-ийн хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах үйл ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Хан-Уул дүүргийг төлөөлж Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр, Боловсролын хэлтсийн дарга Ж.Огтонхорлоо болон холбогдох албан хаагчид оролцсон бөгөөд "Юнител" ХХК-ийг төлөөлж байгууллагын бизнесийн газрын захирал Б.Энхтувшин оролцсон.



#### **Санамж бичгийн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:**

COVID-19 цар тахлын хөл хорио тогтоосон энэ үед нийт Хан-Уул дүүргийн сурагчдад зориулж нийгмийн хариуцлагын хүрээнд үнэ төлбөргүй 10,000ш дататай дугаараар хангах, сурагчдад хичээлийн хоцрогдол үүсгэхгүй байлгахын тулд шаардагдах вэбсайтруу [www.econtent.edu.mn/](http://www.econtent.edu.mn/) хязгааргүй, үнэгүй холбогдоход зориулж шийдлийг гаргах.

“Юнител” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран Хан-Уул дүүргийн нийт багш, албан хаагчдын мэдлэгийг чадавхижуулах, багаар ажиллах чадварыг сайжруулахын тулд цоо шинэ Дижитал “ECO-QUIZ” асуулт хариултын уралдаан, тэмцээнийг 100 хувь санхүүжүүлэн зохион байгуулах.

Хан-Уул дүүргийн нийт багш, сурагчдад цаг алдалгүй мэдээ мэдээллээр хангах, масс мессэж бичих програмыг үнэ төлбөргүй болгож хамтран ажиллах юм.

Мөн Хан-Уул дүүрэгтэй хамтын ажиллагаатай Япон Улсын Мусашимураяама хотын Засаг дарга Macaruy Fuzino 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зуурдаар таалал төгссөнтэй холбоотойгоор эмгэнэлийн захидал ар гэрийхэн болон Мусашимураяама хотын захиргаанд илгээсэн.

#### **Бусад ажлын хүрээнд:**

2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Хан-Уул дүүргийн удирдлагууд, Poonam Pillaiгаар ахлуулсан Дэлхийн банкны ажлын хэсэг, Монгол дахь төслийн багтай онлайн уулзалт хийсэн.

Энэхүү уулзалтын зорилго нь Улаанбаатар хотын өрсөлдөх чадвар ба нөхөн сэргээлтийг сайжруулахаар төлөвлөж буй төслийг тодорхойлох бөгөөд Монгол Улсын тэргүүлэх чиглэл тэр дундаа арьс шир, ноосны салбарын ажлын байрны өсөлт, өрсөлдөх чадварыг сайжруулах, хот суурин газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаагаар дамжуулан Улаанбаатар хотын амьдрах орчин нөхцөл байдлыг сайжруулах юм.

Улаанбаатар хот нь Монгол Улсын улс төр, санхүү болон аж үйлдвэрийн төв цэг бөгөөд урд талдаа ундны усны эх үүсвэр болох Туул голын усны хагалбар дээр байрладаг. Голын хоёр эрэгт мэдэгдэхүйц өсөлт явагдаж, голын эрэг элэгдэж, усны түвшин ба чанар буурч, хотын оршин сүгчдын урт хугацааны усны аюулгүй байдалд эрсдэл учруулж байна. Арьс шир болон ноос боловсруулах үйлдвэр ажиллуулдаг бичил жижиг, дунд үйлдвэр /БЖДҮ/-үүдийн ялгаруулдаг бохирдол нь Туул голын доройтолд нөлөөлж, голын биологийн олон янз байдал, намгархаг хэсгийн эрсдэлд оруулж байна.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд МУЗГ, ялангуяа Сангийн яам /СЯ/, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/, Улаанбаатар хотын захиргаа /УБХЗ/ болон Дархан-Уул аймаг /ДУА/-аас үйлдвэр, технологийн парк байгуулж, арьс шир болон ноос боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлж, Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Туул голын эрэг орчмын хот суурин газрыг нөхөн сэргээхийн санал болгож буй юм.



Шагнал урамшуулал:

Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар тодорхойлогдсон 375 иргэний материалыг хүлээн авч дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар дэмжин батлуулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлан дэмжүүлж, шагнал урамшууллын [www.intranet.gov.mn](http://www.intranet.gov.mn) программд оруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 2 удаагийн зарлигаар Төрийн дээд одон Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 15, Цэргийн гавьяаны одонгоор 10, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 40, Алтан гадас одонгоор 115, Хөдөлмөрийн хүндэт медалиар 189 нийт 359 иргэн тус тус шагнагдаж, Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонгоор 555 иргэн шагнагдсан.

Хан-Уул дүүргийн шагналын журмыг ДИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, дараах төрлийн шагналын загвартай болсон. Үүнд:

1. Хан-Уул Хангарди
2. Хан-Уул Хүндэт тэмдэг
3. Манлайлагч залуу тэмдэг
4. Манлайлагч сурагч тэмдэг
5. Бүтээлч байгууллага шалгаруулах үндсэн 5 шагналын загвар байхаар заасан.

***Хороодтой холбоотой хийсэн ажлын чиглэлээр:***

"Хорооны хөгжил" дэд хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, дэд хөтөлбөрийн салбар зөвлөлийг дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/122 дугаар захирамжаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/311 дүгээр захирамжаар тус тус батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хороодын бүтэц, орон тооны судалгааг гарган 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, "Хан-Уул дүүргийн хороодын бүтэц, орон тоог батлах тухай" дүүргийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/147 дугаар захирамжаар батлуулсан.

"Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг" болзолт уралдааныг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай дүүргийн Засаг даргын А/169 дүгээр захирамжийг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр батлуулж, холбогдох хэлтэс, албадад цахимаар хүргүүлж, хороодод төлөвлөгөө гарган ажиллах тухай албан бичгийг хүргүүлсэн.

Хэсгийн ахлагчдыг томилж, чөлөөлөх шийдвэрийн төслийг тухай бүр боловсруулж батлуулж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар ажилд томилогдсон-44, ажлаас чөлөөлөгдсөн-38, жирэмсний амралттай-3 нийт 85 байна.

Хэсгийн ахлагч нартай байгуулах "Хөлсөөр ажиллуулах гэрээ"-нд холбогдох өөрчлөлтийг оруулан, ЗДТГ-ын хэлтэс, албадын дарга нараас нэмэлт санал авч нэгтгэн 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Б/155 дугаар тушаалаар батлуулсан. 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 21 хорооны 211 хэсгийн ахлагчтай гэрээ байгуулсан.

Засаг даргын Тамгын газрын даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус дүүргийн 15 дугаар хорооны албан хаагчдын албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоох, дүүргээс хэрэгжүүлж буй бодлогын зорилт, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, дотоод ажлын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээнд чанар ахиц гаргах зорилгоор батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан.

Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комиссын чиглэлийн дагуу 2021 оны 2 сарын 11-ний өдрөөс шилжих Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийн үед нийслэлийн хэмжээнд "Нэг хаалга-Нэг шинжилгээ" тандалт илрүүлгийн ПСР шинжилгээг зохион байгуулахаар болсонтой холбогдуулан дүүргийн хэмжээнд шинжилгээ авах байр, гудамжны судалгааг гаргаж, шинжилгээ авсан өдрүүдийн мэдээг цаг тутам нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн Шуурхай штабт мэдээлж ажилласан.

Хан-Уул дүүргийн хороодын үйлчилгээг иргэдэд ойртуулах, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор зарим хороодын хүн амын тоо, төлөвлөлт, газар нутгийн байршилыг судлах, хороодын хилийн цэс өөрчлөх эсэх талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/233 дугаар захирамжаар батлуулсан. Мөн холбогдох судалгаа, мэдээллийг гарган 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэсэн.

#### Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар нь нийт 2269 албан бичгийг цахим болон цаасан хэлбэрээр хүлээж авсан бол 2020 оны эхний хагас жилд 2116 бичиг хүлээн авсан буюу энэ хугацаанд ирсэн бичгийн тоо 153-аар өссөн байна. Нийт албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 2021 оны эхний хагас жилд 94,49% байсан бол 2020 оны эхний хагас жилд 93,69% байна.

Хариутай бичгийн тоо 2020 оны эхний хагас жилд 186 байсан бол 2021 оны эхний хагас жилд 172 буюу 14 хариутай албан бичгээр буурсан бөгөөд хаалтын хувь нь 2020 оны эхний хагас жилд 91,17%, харин 2021 оны эхний хагас жилийн байдлаар 93,33% байна.

Зөрчлийн тоо 2020 оны эхний хагас жилд 250 байсан бол 2021 оны эхний хагас жилд 276 буюу 16-аар өссөн байна.



#### Хан-Уул дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн мэдээ:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем ашиглагч нийт 100 байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 7 хоног тутамд гаргаж Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нийт 7 мэдээг бэлтгэн танилцуулсан байна.

Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж дээд шатны байгууллагад танилцуулан ажилладаг. Энэ ажлын хүрээнд сар тутмын 6, улирал тутмын 1 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлээд байна.



Тус дүүргийн хэмжээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар 19803 албан бичгийг хүлээн авч шийдвэрлэсэн бол 2021 оны эхний хагас жилд 17241 буюу 2562-оор буурсан байна.


Дүүргийн хэмжээнд нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 2020 оны эхний хагас жилд 96,76% байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар 97,48% байна.

Хариутай бичгийн тоо 2020 оны эхний хагас жилд 4686 байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар 3434 буюу 1252-аар буурсан бөгөөд хаалтын хувь нь 2020 оны эхний хагас жилд 98,62%, харин 2021 оны эхний хагас жилийн байдлаар 97,8% байна.

Зөрчлийн тоо 2020 оны эхний хагас жилд 723 байсан бол 2021 оны эхний хагас жилд 716 буюу 6-аар буурсан байна.

#### Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд явуулсан бичгийн мэдээ:

Засаг даргын Тамгын газраас төлөвлөн явуулсан албан бичгийн тоо 2020 оны эхний хагас жилд 1355 байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1048 буюу явуулсан албан бичгийн тоо 307-оор буурсан байна.



Дүүргийн хэмжээнд явуулсан албан бичгийн тоо 2020 оны эхний хагас жилд 8849 байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар 8260 буюу явуулсан албан бичгийн тоо 549 -оор буурсан.

#### Дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт хийсэн мэдээ:

Нийслэлийн Архивын Газрын даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар дүүргийн төр, захиргааны байгууллагуудын баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих эрхийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор шилжүүлсэнтэй холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажилласан мэдээг сар тус бүрээр графикт харуулав.



Тус ажлын хүрээнд тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт өссөн дүнгээр 15570 албан албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж үүнээс 15438 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалттай гэж үзэн баталгаажуулж, 132 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалтгүй гэж үзэн цуцалсан байна.

#### Захирамж, тушаалтын мэдээ:

Д/Д	Төрөл	2020.06	2021.06
1	Засаг даргын А захирамж	261	302
2	ЗДТГ-ын даргын А тушаал	73	65
3	Нийт	334	367

Дүүргийн Засаг даргын А захирамжийн тоо 41, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаалын тоо 12, нийт захирамжлалын баримт бичгийн тоо 29-өөр өссөн байна.

#### Архивын чиглэлээр:

Архивын Ерөнхий газрын даргын 2018 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын дагуу дүүргийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх эх үүсвэрийн жагсаалтад орсон дүүргийн харьяа 102 байгууллагаас 84 байгууллагын архивын тоон тайланг <http://burtgel.archives.gov.mn/> системд цахим хэлбэрээр шивэх ажлыг хугацаанд нь хийж дүн мэдээг Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын дотоод хэлтэс тасгуудад 2020 онд үүссэн цаасан суурьт 536 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч эмхлэн цэгцэлж, дугаарлан лавлагаа хуулбар өгөхөд бэлэн болоод байна.

“Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх” ажлын хүрээнд 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримтад цахим хувь үйлдэн онлайн хэлбэрээр мэдээлэл, лавлагаанд ашиглуулах нөхцлийг ханган ажиллаж байна.

Дүүргийн харьяа 91 байгууллагын 169 хөмрөгийн 8558 захирамжлалын 13391 хуудас баримтыг Archive edoc системд шивснийг батлан шалгаж дуусгасан.


Монгол улсын Архивын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу 955 лавлагаа хуулбар, дотооддоо 158 баримтыг түр ашиглуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийг хөтлөх хэргийн нэrsийн жагсаалтын дагуу 62 хэсгийн хорооны Байнга хадгалах-66 хадгаламжийн нэгж, Түр хадгалах-126 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, Нийслэлийн архивын газарт хүлээлгэн өгсөн.

2021 онд Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийгдэх Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Биеийн тамир спорт хороо, Эрүүл мэндийн төв, Соёлын ордон зэрэг төлөвлөгөөт 5 байгууллагын данс бүртгэлд арга зүйн заавар зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.


Утасны лавлагаа хэвлэл мэдээллийн чиглэлээр: 2021 оны эхний хагас жилийн байдлаар лавлах утсанд нийт 7609 дуудлагыг хүлээн авч хариу мэдээлэл өгсөн.

*Хагас жилийн байдлаар лавлах утсанд ирсэн нийт дуудлагын үзүүлэлтийг графикаар харуулвал:*



Лавлах утсанд хандаж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд гол төлөв дараах хэлтэс, албадаас мэдээлэл авч холбогддог. Үүнд

## Үзүүлэлт



Дүүргийн лавлах утсанд хагас жилийн байдлаар нийт 15 өргөдөл, гомдлыг хүлээн авсан хариуцсан ажилтанд мэдэгдэн шийдвэрлэж ажилласан.

Мэдээлэл технологийн чиглэлээр:

Засаг даргын Тамгын газар, хороодод 2021 оны эхний хагас жилийн байдлаар компьютер болон дагалдах техник хэрэгслийн засварын чиглэлээр нийт 62 ажил, сүлжээний доголдлын 15 ажил хийгдэж, Вэб сервер, Санхүүгийн сервер, цаг бүртгэлийн сервер, CMC илгээх програм хангамжийн сервер, Kaspersky серверуудийн байнгын найдвартай хэвийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.



Мөн Khanuuil.mn домэйн нэр болон цахим шууданг шинээр 65 хэрэглэгчийг үүсгэж гэрээг “Мэйжик нэт” ХХК-тай үргэлжлүүлэн сунгаж хамтран ажиллаж байна.

Засаг даргын Тамгын газрын 1 давхрын засвар хийсэн 2 өрөө болон 1 хороо, Монгол билэг оюу, Удирдлагын академи, 41 дүгээр сургууль, 35 дугаар цэцэрлэгийн вакцины цэгт шинээр сүлжээ татаж, дүүргийн онцгой комиссын гишүүд болон 21 хороодын шуурхай онлайн хурлыг 2,4,6 өдөр бүр нээж, нийт 45 удаа хуралдлаа. Ахмадын хороо, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Худалдан авах ажиллагааны албатай интэрнетийн үйлчилгээ ашиглуулах 1 жилийн гэрээ байгуулсан.

**САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**Дүүргийн төсвийн орлогын талаар

2021 оны эхний 6 дугаар сарын төлөвлөгөөгөөр орон нутгийн төсөвт 38,000,706,8 мян төгрөгийн орлого орохоос урьдчилсан гүйцэтгэлээр 31,770,634.1 мянган төгрөг орж, 83.6 хувийн биелэлттэй буюу 16.4 хувиар тасарч байна.

Дүүргийн 2021 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг нийт 13-н дансны 1-12 сарын орлого болон зарлагын гүйлгээгээр тулган хянаж, Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай тооцоо нийлэн дүүргийн Нэгдсэн Санхүүгийн тайланд амжилттай нэгтгэгдлээ. 2021 оны эхний 6 сарын орлого болон зарлагын гүйлгээг тулган хянаж, албан тоотын дагуу зарлагын гүйлгээг Төлбөрийн хүсэлт бичин гаргаж, Татварын хэлтсийн орлогын байцаагчид 7 хоногт 4-5 удаа хуулгыг тогтмол илгээн тулган, тооцоо нийлэн ажиллаж байна. Дүүргийн 2021 оны төсвийн орлогын хуваарийг хийж, Засаг даргаар батлуулан, Фрийбаланс программд оруулан орон нутгийн санхүүжилтийг саадгүй явуулах нөхцөл бололцоог ханган ажиллалаа.

“Улс, нийслэл болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2021 онд жигд ханган биелүүлэх тухай” Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/23 дугаар захирамжийн төслийг боловсруулан батлуулж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Энэхүү захирамжийн дагуу төлөвлөгөө тасарсан татварын орлогуудын талаар хийх ажил, анхаарах

асуудлын талаар Татварын хэлтэстэй хамtran ажилласан. Тухайлбал: Хог хаягдлын хураамжийн орлогын сар бүрийн гүйцэтгэлийг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул Агро ОНӨААТҮГ, Хан-Эко тээвэр ОНӨААТҮГазартай гэрээний дагуу тооцоо нийлж сар бүрийн 03-ны дотор тогтмол ирүүлж хэвших, хамtran ажиллах талаар уулзалт зохион байгуулсан.

Төсвийн сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах зорилгоор Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн A/136 дугаар захирамжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл хүргүүлэн Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу зардлын эрэмбэ тогтоон төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Орон нутгийн 2020, 2021 оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсвийн тодотголын саналыг урьдчилсан байдлаар файл болон илтгэл хэлбэрээр боловсруулан, удирдлагад танилцуулсан.

#### **Нийслэлд төвлөрүүлэх орлогын талаар:**

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн төсөвт орон нутгийн төсвөөс 11 335 380.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 83,4 хувийн биелэлттэй байна.

**Улсын Тэмдэгтийн хураамж буцаан олгох талаар:** Төсвийн “тэг” үлдэгдэлтэй данснаас гарах зардлын гүйлгээний баримтуудыг нэг бүрчлэн тулган хянан 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтаар нийт 522,061,674 төгрөг 98 мөнгийг 803 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгов. Мөн нэр данс зөрүү болон запруулгын гүйлгээг Татварын хэлтсээс ируулсэн албан бичиг, жагсаалт, дансны хуулга зэрэг үндсэн баримтыг үндэслэн 25 иргэн, аж ахуйн нэгжид 315,184,790 төгрөг 70 мөнгө буцаан олголоо.

#### **Бүртгэлийн үйлчилгээний талаар:**

Хан-Уул дүүрэгт харьялагдах аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Зөрчил шалган шийдвэрлэх, Зөрчлийн тухай хууль, Сангийн сайдын 46-р тушаалыг баримтлан Тайлан баланс, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг Сангийн яамны шинэчилсэн “E-Balance” нэгтгэлийн программд бүрэн шивүүлж илгээсэн тайланг заасан хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан, нэгтгэлийг заавар журмын дагуу тайлагнаж байна.


Нэгтгэлийн программд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан өгвөл зохих нийт 14208 аж ахуйн нэгж, байгууллагаас 11518 тайлан буюу 81,1%-ийг цахим системээр ирүүлсэн байна. Үүнээс 10425 байгууллага буюу 73,3%-ийг баталгаажуулж, 1101 байгууллагын алдаатай болон аудитын байгууллагын нэрийн баталгаажуулалт хийгдээгүй тайланг буцаасан.

1810 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.




- Сар бүр Прокурорын газарт Шийтгэл оногдуулалтын мэдээг хүргүүлж байна.
- Шинээр ААНБ бүртгэхэд шаардлагатай материал, тайлан хүлээн авалттай холбоотой мэдээллийг тогтмол хүргэж байна.
- Өмнөх оны 8 зөрчлийн хэргийн 5 зөрчлийг хэрэгсэхгүй болгож, 3 зөрчил дээр шийтгэлийн хуудас бичсэн. Дээрх зөрчлийн 2 нь Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүх хурлууд Ковид-19 цар тахалтай холбоотой хойшилсон байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцсон байдал



## 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛТ



- Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд Дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 77 байгууллагын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайландаа байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авч баталгаажуулан Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Нийслэлийн Аудитын байгууллагад хүргүүлэн амжилттай шалгагдаж, “Стандарт дүгнэлт” авсан.

### Санхүүжилт олгосон талаар:

Орон нутгийн байгууллагуудад олгосон санхүүжилт: 2021 оны дүүргийн орон нутгийн 33 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсвийн дагуу боловсруулж, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 56,614.2 сая төгрөгийн батлагдсан төсвийг байгууллага тус бүрийн жилийн төлөвлөгөө, төсвийн сар, улирлын орлого, зарлагын хуваарийг хийж батлуулсан санхүүжилтийг

олгуулан ажилласан. Эхний 6 сарын байдлаар 31,866.5 сая төгрөгийн төсвийн хуваарийг сар бүр хийж батлуулан санхүүжилтийг хугацаанд нь олгуулсан. Тайлант хугацаанд 37 байгууллагад 1,406.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг нээсэн.

№	Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд	06-р сарын ЗЭБ	Эхний 06 сарын ЗЭБ /Өссөн дүнгээр/
1	ИТХ	495,953.0	1,890,621.9
2	ЗДТГ	984,507.6	5,677,076.3
3	Туул тосгоны ажлын алба	42,708.5	250,934.0
4	ХАААлба	21,800.6	140,778.6
5	Дотоод аудитын алба	22,061.5	123,764.7
6	ЖДҮДТөв	27,959.1	237,716.4
7	ГБХЗХХэлтэс	47,787.5	291,945.4
8	УССТөв	37,819.1	245,824.3
9	БТСХороо	1,400.0	66,805.7
10	Соёлын ордон	28,006.8	199,659.3
11	Аж ахуйн тооцоот байгууллагууд	1,133,085.3	6,342,474.5
12	Төсвийн хөрөнгө оруулалт	2,500,000.0	9,000,000.0
13	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг	2,833,845.0	17,003,070.0
14	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлууд	144,375.9	2,994,788.4
15	Орон нутгийн хөгжлийн сан	60,279.4	959,949.9
<b>Нийт санхүүжилт</b>		<b>8,381,589.3</b>	<b>45,425,409.4</b>

Тусгай шилжүүлгийн байгууллагуудад олгосон санхүүжилт:

Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 56,614.2 сая, орон нутгийн төсвөөс санхүүжих 6,389.0 сая төгрөгийн батлагдсан төсвийг төсвийн төлөвлөлтийн фискал программд байгууллага тус бурийн жилийн төлөвлөгөө, төсвийн сар улирлын орлого, зарлагын хуваарийг эдийн засгийн ангилалын дагуу шивж оруулан баазийг нэгтгүүлэн, Сангийн яаманд хүргүүлж санхүүгийн удирдлагын мэдээллийг системд татуулан гүйлгээ хийх боломжийг бүрдүүлэн ажилласан.

№	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд	6-р сарын Санхүүжилт	6-р сарын санхүүжилт /Өссөн дүнгээр/
1	Сургууль	3,937,592.3	15,127,110.7
2	Цэцэрлэг	1,336,560.6	13,713,835.7
3	Өрхийн эмнэлэг	452,599.3	2,715,595.8
4	Нийт санхүүжилт	5,726,752.2	31,556,542.2

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор 50% хязгаарлагдсан байсан тээвэр шатахуун, шуудан холбоо интернэт, хог хаягдал ариутгалын зардлуудын төсвийг төсвийн төлөвлөлтийн фискал програмд 48 байгууллага болон 3 зардлын ангилал тус бүрээр 4-12 саруудад батлагдсан төсвийн хүрээнд төсөв хоорондын харилцаанд тааруулан, Боловсрол шинжлэх ухааны яам, Нийслэлийн боловсролын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу ерөнхий боловсролын 19 сургуулийн лаборатори болон ур чадвар нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалд 1,800.9 сая төгрөгийн санхүүжилтийн өөрчлөлтийг 2-12 дугаар саруудын төсвийн хуваарыг өөрчлөлт оруулан, төлөвлөлтийн програмд шивж баазаа Нийслэлийн СТСХэлтэс, Сангийн яаманд хүргүүлэн нэгтгүүлж, зарцуулалтын эрхийг нээлгэсэн.

Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн талаар:

2020 -2021 онд он дамжин хэрэгжиж буй Ахмадын сувилал барих ажлын гэрээний хугацаа сунгаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан баталгаажуулсан. Шууд гэрээний ажлын хэсгээс ирүүлсэн Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил хянагдаж гүйцэтгэгчээр "Хурд" ХК шалгарч, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулсан.

Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт, мөн түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нийтийн эзэмшлийн тохижилт /ногоон байгууламж/ зэрэг төсөл арга хэмжээний 3 гэрээ байгуулсан байна.

Өвөлжилтийн бэлтгэл хангах зардлаас Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн байрны дээврийн засварын ажлын гэрээ байгуулав.

Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах зардал, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт 243 667,7 сая төгрөгийн гүйцэтгэлийг хянан санхүүжүүлсэн байна.

Мөнх Чандмань элч ХХК, Юубокүр ХХК-ийн барьцааг дүгнэн портocol үйлдэж, барьцааг чөлөөлөн олгосон. Шууд гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний тайлан, мэдээ гарган Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Сангийн яаманд сар бүр хуулийн хугацаанд хүргүүлэн мэдээлдэг.

Төрийн сангийн үйлчилгээний талаар: Төрийн сан банк нь харилцагч төсөвт байгууллагуудын дансны нэгдсэн жагсаалт гаргаж, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилан, 2021 оны 01 дүгээр сарын 07-нд батлан, 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдрөөс 6 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 9944 ширхэг 78,391.0 сая төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэн, тулган шалгаж эцсийн байдлаар баталгаажуулсан ажилласан.

Төсөвт байгууллагуудын баталгаат гарын үсгийг маягтын дагуу 11 төсвийн шууд захирагч, 13 нягтлан бодогч журмын дагуу шинэчлэн авч, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд бэлтгэн нийлүүлэгчээр 268 байгууллага болон хувь хүн бүртгэсэн байна.

Сургалт, тайлан мэдээний талаар:

Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд орон нутгийн байгууллагууд 16, өрхийн эрүүл мэндийн төв 16, улсын төсвийн цэцэрлэг 28, сургууль 19, хувийн сургууль 25, цэцэрлэг 98, нийт 202 байгууллагын мэдээ нэгтгэгдэн, улсын төсвийн цэцэрлэг, сургууль болон орон нутгийн байгууллагуудын 1-5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны програмтай тулган баталгаажуулсан ажилласан.

Орон нутгийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, тайланын аудитын дүгнэлт гэсэн нийт 12 төрлийн мэдээг 1-5 дугаар саруудад Shilendans.gov.mn сайт, дүүргийн веб хуудасны Мэдээллийн ил тод байдал хэсэгт тус тус байршуулан иргэд, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэн ажиллалаа.

2020 оны жилийн эцсийн тайлангийн нэгтгэлийг 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар болон Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

Дүүргийн төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг шалган зааварчлах, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд 2 удаагын цахим хурал зохион байгуулж, Аудитын дүгнэлтийн мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн. Мөн 2021 оны 1 дүгээр улирлын тайлан хүлээж авахтай холбогдуулан цахим хурлаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

"Дүүргийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу Нийслэл дэх Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй гарсан, зөрчлийг аудитын явцад запруулсан байгууллагудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч, эд хариуцагч нарт үндсэн цалингийн 1-1,5 сараар бодож урамшуулал олгох, зөвлөмж, акт албан шаардлага авсан төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтнуудад хариуцлагын арга хэмжээ авч ажиллалаа.

Сангийн яамны Төрийн албаны цалингын нэгдсэн системийн сургалт, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн 2 удаагийн сургалт, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын хаврын сургалтуудад хамрагдах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.


#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Коронавируст халдварт илрүүлэх PCR шинжилгээг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байранд үйл ажиллагаа явуулж буй хэлтэс, албадын ажилтан, албан хаагчдаас авсан.

Тус байранд нийт 294 ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас 129 буюу нийт ажилчдын 38% нь PCR шинжилгээнд хамрагдсан байна.



2021 оны 02 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын орлогч А.Амартувшин, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга О.Мягмарсүрэн, салбар хариуцсан мэргэжилтэн, дүүргийн Эрүүл мэндийн төвийн Өрхийн менежер Г.Даваасүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн өнөөгийн үйл ажиллагааны байдалтай танилцан, санал хүсэлт, тулгамдаж байгаа асуудлуудын талаар хэлэлцэж, зөвлөгөө өгч ажилласан.



Ажлын байранд Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, албадын албан хаагчдад амны хаалт, гар ариутгагч, халдварт хамгааллын хэрэгслийг 2 удаа олгосон.




“Цусаа хандивлая” аяныг Цусны төвтэй хамтран 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадын нийт 58 албан хаагчид цусаа хандивлан цусны донорын эгнээнд нэгдэцгээсэн.

Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо буюу Био комбинатын “Жишиг ерхийн эмнэлэг”-ийн шинэ барилга ашиглалтад орох үйл явцтай дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, орлогч дарга А.Амартувшин болон бусад холбогдох албаны хүмүүс 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдөр танилцсан.



#### СӨЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭР

Ардын хувьсгалын 25 жилийн ойн өндөрлөг



Зөвлөлтийн дайчдын хөшөө

Ардын хувьсгалын 40 жилийн ойн өндөрлөг



Бурхантай хөшөө

Соёмботой уулын Соёмбо болон бичээс



Ажилчны алдар хөшөө

Хан-Уул дүүргийн өдөрлөг



❖ Эдгэр хөшөө, дурсгалуудыг сэргээн засварлах шаардлагатай тэж үзүүн Засгийн газрын хэрглүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт санал хүргүүлэхээр болжтэй.

Дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай, яаралтай засварлах шаардлагатай хөшөө дурсгалын судалгааг гаргаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үүнд:

- Ардын хувьсгалын 25 жилийн ойн өндөрлөг- Шаардагдах төсөв болон газрын кадастрын зургийг хийлгэсэн бөгөөд Нийслэлийн газрын мэдээллийн санд бүртгүүлэхээр хүсэлтийг хүргүүлсэн.
- Соёмбот толгойн гэрэлтүүлэгийн ажил- Шаардагдах төсвийг гаргаж, төсвийн тодотголд суулгах санал хүргүүлсэн.
- Хан-Уул дүүргийн 50 жилийн ойн өндөрлөг- Шаардагдах төсвийг гаргаж, төсвийн тодотголд суулгах санал хүргүүлсэн.



**Олон улсын болон төрийн бус байгууллагын чиглэлээр:**

Тус дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Тайваны Хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газартай 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдөр "Хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулсан. Санамж бичгийн 2.1.4 дэх хэсэгт заасны дагуу Тайваны Хүүхэд гэр бүлийг дэмжих сангаас 30,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, дүүргийн Эрүүл мэндийн төвийн "Шүдний гажиг заслын кабинет"-д иж бүрэн засвар болон тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

Шүдний гажиг заслын кабинет нь сард, шүдний эмчилгээний чиглэлээр 220-330 хүнд, гажиг заслын чиглэлээр 44 хүнд үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтайгаар 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн.



Тус дүүргийн Засаг даргын Тамгын газар нь "Гүүд нэйборс" ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газартай 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 5 жилийн хугацаатай "Хамтын ажиллагааны гэрээ" байгуулсан. Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд дараах ажлуудыг хамтран хэрэгжүүлээд байна. Үүнд: Хан-Уул дүүргийн 4, 5, 6 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн "Дархлаажуулалтын өрөө"-нд нийт 35,000,000 төгрөгийн засвар болон бүрэн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.



60 дугаар сургуулийн "Сэтгэл зүйн зөвлөгөөний өрөө"-г нийт 1,589,000 төгрөгийн төсвөөр тохижуулсан.



Коронавируст халдварт /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр Хан-Уул дүүргийн 29, 71, 145, 189 дүгээр цэцэрлэг, 34, 41, 60 дугаар сургууль тус бүрд ариутгалын төхөөрөмж олгосон. Төсөв-1,000,000 төгрөг

Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт хамрагддаг 1496 хүүхдийн нийт 850 өрхөд 85,000,000 төгрөгийн хүнсний болон эрүүл ахуйн багц олгосон.



2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр тус дүүргийн 14 дүгээр хороонд байрлах "Өлзийт Асар" төрийн бус байгууллагын түр хоноглох байрны 360м<sup>2</sup> талбайд "Сайн түшиг" ХХК ариутгал, халдвартгүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Тус байранд орон гэргүй, гудамж талбайд хоноглон тэнүүчилж амьдардаг, гэр орноосоо дайжсан, архины хамааралтай иргэдийг байршуулан нийгэмшүүлэх үйлчилгээнд хамруулж байна. Иргэдийг коронавируст халдварт /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсээс 2000 ширхэг амны хаалт, 100 ширхэг гар ариутгагч бүхий халдварт хамгааллын хэрэгслийг хүлээлгэн өгсөн.

Дүүргийн Улаан Загалмайн хороо, Нэгдсэн Үндэсний байгууллагын Шилжилт хөдөлгөөний байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, "Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн" ТББ-удын дэмжлэгтэйгээр 2021 оны 05 дугаар сараас 2021 оны 09 дүгээр сар хүртэлх хугацаанд хэрэгжих "Дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдлыг хязгаарлах нь" төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/269 дүгээр захирамжаар байгуулж, төслийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.



Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй нийт 32 байгууллагын төслийг хүлээн авч, хэлтсийн хурлаар төслүүдийг хэлэлцэж, 15 төслийг хэрэгжүүлэхээр санал болгон дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 4/335 дугаар албан бичгээр тус хөтөлбөрт хүргүүлсэн.

№	Байгууллагын нэр	Төслийн нийтийн нэр	Төслийн нийтийн тайлбар	Тайлбар	
				Нийтийн нийтийн тайлбар	Тайлбар
1	ОДН-СОГУЛУУ	ЗААНЫНЧ	Сагатынчийн, А. Б. Балын нийтийн ислийн хөтөлбөрт хүргүүлсэн	201.112.161	
2	Залуут шигүүр чад	Э.БААЧИЙН	Мургуулжилж, эзүүнчилж, төрөлжилж, дэвшиж хөтөлбөрт хүргүүлсэн	16.307.379	
3	БТРС	В.БААЧИЙН	Сагатынчийн, Э.Б. Балын нийтийн ислийн хөтөлбөрт хүргүүлсэн	134.471.850	
4	Чинхамчийн Фонд	И.БААЧИЙН	Чинхамчийн Фондийн, Чинхамчийн Фондийн ислийн хөтөлбөрт хүргүүлсэн	49.342.751	
5	СЭРГИЙЛЭХ	Р.Нямжидж	Сэргийлийн ялангуяа ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	320.201.850	
6	180-ийн дэвшиж	Б.БААЧИЙН	Дэвшижийн бийн, сагатынчийн, залуут шигүүр чад хөтөлбөрт хүргүүлсэн	42.211.911	
7	201-ийн дэвшиж	Ч.ЧАЛАНГУУЛСАН	Дэвшижийн бийн, сагатынчийн, залуут шигүүр хөтөлбөрт хүргүүлсэн	931.764.022	
8	41-ийн дэвшиж	Д.Зоригтуяа	Дэвшижийн бийн, сагатынчийн, залуут шигүүр хөтөлбөрт хүргүүлсэн	29.142.061	
9	Үнэчийн Фонд	Г.Аицэвэр	Үнэчийн Фондийн ялангуяа ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	26.783.117	
10	Залуут шигүүр Фонд	И.Ачилтуяа	Залуут шигүүр Фондийн ялангуяа ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	895.399.150	
11	Шалан Шигүүр Фонд	Ч.Доржжавын	Шалан Шигүүр Фондийн ялангуяа ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	16.375.758	
12	33-ийн дэвшиж	Ч.Чадваджан	Дэвшижийн бийн, сагатынчийн, залуут шигүүр хөтөлбөрт хүргүүлсэн	95.734.001	
13	ЗАА-СОГУЛУУ	Р.Нямжидж	ЗАА-СОГУЛУУ ялангуяа ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	257.194.650	
14	Мис-Соогүүл	Д.Доржсүрэн	Соогүүлийн, шигүүрийн ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	58.087.881	
15	Түүвэрчийн Фонд	Д.Батсүрэн	Түүвэрчийн Фондийн ялангуяа ислийн, төслийн хөтөлбөрт хүргүүлсэн	42.000.000	



#### Боловсролын чиглэлээр:

Ковид-19 цар тахлын үед зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотойгоор дүүргийн төрийн сургуулийн сурагчдад хичээл завсардлаас урьдчилан сэргийлэх, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “ДАТАТАЙ ДУГААР” олгох үйл ажиллагааг дүүргийн Боловсролын хэлтэс, “Юнител” ХХК болон Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 сургуулийн 5-12 дугаар ангийн нийт 10.000 сурагчдад “ДАТАТАЙ ДУГААР” олгогдсон.

Гэртээ зурагтгүйгээс “Теле хичээл” үзэх боломжгүй, дүүргийн зорилтот бүлгийн болон олон хүүхэдтэй өрх толгойлосн 3 өрхөд зурагт болон дататай дугаар гардуулж, тус 3 өрхийн сургуулийн насны хүүхдүүд хичээл хоцрогдоос сэргийлэх боломжийг бүрдүүлсэн.



Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 сургуулийн захирал, 28 цэцэрлэгч нартай 2020 онд байгуулсан “Үр дүнгийн гэрээний сүүлийн хагас жилийн үнэлгээ” болон “Үр чадварын нэмэгдэл”-ийг дүүргийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын 19 сургуулийн захирал, 28 цэцэрлэгийн эрхлэгч, 21 хорооны Засаг дарга нартай хамтран 2021-2022 оны хичээлийн жилийн хамран сургах тойргийг шинэчлэн Нийслэлийн боловсролын газарт хүргүүлсэн.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын 19 сургуулийн спортын талбайн ашиглалт, хамгаалалт, шаардлагатай засвар болон шинээр тохижуулах ажлыг судалж, тайлагнах ажлын хүрээнд 19 сургуулийн спорт, биеийн тамирын талбайтай газар дээр нь очиж танилцсан.



#### **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр:**

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/113 дугаар захирамжаар дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсан. Зөвлөлийн бүрэлдэхүүн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хуралдаж, сарын аяны хугацаанд болон тухайн жилд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэж, төлөвлөгөө боловсруулсан.



Зөвлөлийн гишүүн, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн хүрээлэн”-ийн Захирал Д.Батбаатар 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зөвлөлийн гишүүдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад тус зөвлөлийн 9 гишүүн хамрагдан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгээ сайжруулж, тус зөвлөлийн чиг үүрэг, ажиллах журмын талаар нэгдсэн ойлголттой болсон.



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2021” арга хэмжээг “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлье” уриан дор цахимаар зохион байгуулсан.

Коронавируст /Ковид-19/ халдвартын улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед зөвлөлийн бүрэлдэхүүн “Safety First-ХАБЭА-н мэдлэг мэдээлэл” пэйж хуудаст бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч эзэд, ХАБЭА-н ажилтнуудад зориулсан сургалтуудыг цахим хэлбэрээр үе шаттайгаар зохион байгуулж ажилласан.

Зөвлөлийн гишүүн, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн хүрээлэн”-ийн Захирал Д.Батбаатар “Үйлдвэрлэлийн ослыг судлах дараалал” сэдэвт ажил

олгогч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудад зориулсан сургалтыг 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтад нийт 94 хүн хамрагдсан.

Мөн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн системдээ хөрөнгө оруулалт хийхийн ач холбогдол" сэдэвт ажил олгогч, хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 66 хүн хамрагдсан. Тус сургалтыг нээж, Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч, зөвлөлийн дарга А.Амартувшин үг хэлж, нийт ажил олгогч эзэд, ажилтнуудыг зөвлөлөөс зохион байгуулж буй арга хэмжээ, цахим сургалтуудад идэвхтэй хамрагдаж, хамтран ажиллахыг уриалсан.



Зөвлөлийн гишүүн, "Монкон Консттрашкн" ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албаны дарга Д.Мөнхбат "Барилгын төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагааг зохион байгуулах нь" сэдэвт ажил олгогч, хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудад зориулсан сургалтыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтад нийт 102 хүн хамрагдсан.



Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 58 аж ахуйн нэгж байгууллагуудад хуулийн хэрэгжилт ханганд ажиллах тухай 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01/288 дугаар албан бичгийг хүргүүлсэн.

#### Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагаа:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/64 дүгээр тушаалаар "Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын бүрэлдэхүүн"-ийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус комисс нь 18-аас дээш насны иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 196 удаа хуралдаж, 1871 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Сунгасан-1469
- Шинээр орсон-225
- Цуцалсан- 110
- Буцаасан- 65
- Хөдөлмөрийн нөхцөл сольсон-2

#### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаа:

Дүүргийн Засаг даргын 2017 оны А/129 дүгээр захирамжаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ыг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус комисс нь 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, тогтоох, нийгмийн амьдралд тэгш оролцох боломж, хүртээмжийг дээшлүүлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд 8 удаагийн хурал зохион байгуулж, 189 хүүхдийн асуудлыг хэлэлцэнээс 19 хүүхдэд шинээр байнгын асаргаа, 2 хүүхдэд байнгын асаргаа шаардлагагүй болохыг тогтоож, 3 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлон 168 хүүхдийн

байнгын асаргааг сунгасан. Тус комиссын 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах 900,000 төгрөгийн төсвийг шийдвэрлэсэн.

#### Зорилтот өрхүүдэд үзүүлсэн хүнсний тусlamжийн мэдээлэл:

- ✓ Дүүргийн Засаг даргын 2021 оны А/144 дүгээр захирамжаар хөл хорио болон гэрийн тусгаарлалтад орсон өрхүүдэд 125 хүнсний тусlamж
- ✓ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Дэм дэмэндээ-2” аяны хүрээнд 400 хүнсний тусlamж
- ✓ Улсын Онцгой комиссоос 300 багц хүнсний тусlamжийг тус тус олгосон.



#### Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 60 дугаар зарлиг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн хэмжээнд нийт 68 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулан тогтвортой үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр онлайн сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Цагдаагийн Ерөнхий газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Сургалтад дүүргийн 21 хорооны хамтарсан баг, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн албан хаагчид нийт 147 албан хаагч хамрагдсан.




“Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх аян зохион байгуулах” тухай дүүргийн Засаг даргын А/234 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсэг 4 төрлийн хүчирхийлэлд ертөж буй хүүхдийн судалгааг Цагдаагийн газар, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төв, хороодын хамтарсан баг, Хүүхдийн тусlamжийн 108 утасны дуудлага мэдээллийг үндэслэн гаргасан бөгөөд ажлын хэсэг 180 гаруй хүүхдийн ар гэрт хяналт тавьж, хамгааллын үйл ажиллагааг эрчимжүүлэн ажилласан.

#### Худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжээс ирсэн хүсэлтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн 12 удаа 41 асуудлаар хуралдуулж, тухайлсан шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Үүнд :

- Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулах 544 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан.
- Тамхины тусгай зөвшөөрөл 46 аж ахуй нэгжид олгосон.
- Тамхи худалдан борлуулах 1 тусгай зөвшөөрлийг цуцалсан.
- Нийтийн эзэмшлийн зам талбайд ТҮЦ-ийн зөвшөөрөл хүссэн 10 иргэнд шийдвэр хүргүүлсэн.
- Зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэх чиглэлээр газрын зохион байгуулалтын алба, Мэргэжлийн хяналтын хэлтсээс албан мэдэгдэл, шаардлагыг хүргүүлсэн.
- Газар зүйн мэдээллийн систем Arcgis программд дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн аж ахуйн нэгжийн хариуцсан орчны 50 метрийн зураглалыг оруулан Google earth программд хөрвүүлэн мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. тус программд нийт 300 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулаад байна.
- Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч буй 374 аж ахуйн нэгжид цахим сургалт зохион байгуулж, аттестатчиллын шалгалтад хамрагдах, жижиглэн худалдааны стандарт шаардлагыг хангулан, аж ахуйн нэгжүүдийн гадна фасад, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр үүрэг чиглэл өгч ажилласан.
- "Худалдаа үйлчилгээний салбарын 100" жилийн ойн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж, үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Ногоон зурvas" байгуулах ажилд дүүргийн худалдаа, үйлчилгээ эрхлэгч 35 аж ахуйн нэгж оролцуулж, 50 нарс мод тарьсан.



#### БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР:

##### Цэргийн бүртгэлийн талаар

Дүүргийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/502 дугаар захирамжаар 2020 оны 01 дүгээр сарын 13-27-ны өдрийг дуустал зохион 2021 оны цэргийн бүртгэлийн нэгдсэн семинарыг 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж 21 хорооны Засаг дарга нараас 1, 2, 4, 6 дугаар хорооны Засаг дарга нар оролцогүй ирцийн хувь 86.1, 21 хорооны зохион байгуулагч нар 100 хувийн ирцтэй оролцсон.

2021 оны цэргийн бүртгэлийн нэгдсэн семинарын хөтөлбөрийн дагуу Цэргийн штабын дарга хурандаа Г.Жаргалсайхан, Тоо бүртгэлийн офицер, хошууч Н.Насанбат цэргийн бүртгэлийг зохион байгуулах талаар зөвлөмжийг өгч, териин болон албаны нууцын тухай хуулийн дагуу 21 хорооны Засаг дарга, 21 хорооны зохион байгуулагч нараас төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг /маягт №2/ гаргуулсан.

2021 оны цэргийн бүртгэл зохион байгуулахад хөтлөгдөх маягт, хаяг, сурталчилгааны зурагт хуудас, хорооны цэргийн бүртгэлийн мэдээллийн сан, бүртгэлийн тэмдэг, цэргийн үүрэгтний үнэмлэх бусад шаардлагатай зүйлсийг 21 хороонд бүрэн хүлээлгэн өгсөн.

2021 оны 18-50 насны иргэдийн цэргийн бүртгэлийг зохион байгуулж явуулах дүүргийн Засаг даргын 2020 оны А/502 дугаар захирамжаар батлагдсан комисс, цэргийн бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулах, хороо хариуцсан хэлтэс, албадын дарга нарт цэргийн бүртгэлийг хороонд зохион байгуулах, хяналт тогтоох, хамтран ажиллах, батлан хамгаалах териин үйлчилгээг иргэдэд хүргэх талаар дэмжлэг үзүүлж ажиллах чиглэл зөвлөмж өгч, хороодод ажиллах хуваарийг танилцуулан хэлтэс, албадын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан.


Цэргийн бүртгэлийн бэлтгэл ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 18-55 насны иргэдийн нэрийн жагсаалтыг авч, цэргийн бүртгэлийн мэдээллийн санд хөрвүүлэн мэдээллийн баазтай тулгалт хийн бүртгэлд хамрагдах иргэдийн тоог хороо бүрээр гарган өгч, мэдээллийн сангаас хороодын цэргийн бүртгэлийн мэдээллийн санг файлаар нь гарган бүртгэлийг цахимаар зохион байгуулсан. Бүртгэлийн үед шаарддагах маягт, хүснэгтүүдийг

стандартын дагуу хэвлүүлэн, дүүргийн аж ахуйн нэгж байгууллагад нэрийн жагсаалтаар бүртгэл явуулах албан даалгаврыг хүргүүлэн, мэдээлэл сурталчилгааны ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажилласан.

**Цэргийн бүртгэлийн явц:** 2021 оны цэргийн бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 13-наас 01 дүгээр сарын 27-ны өдрүүдэд Засаг захиргааны үндсэн нэгж хороонд төвлөрүүлэн, хорооны Засаг дарга нар эрхлэн явуулсан. Засаг даргын Тамгын газрын дарга захиргааны удирдлагаар, Цэргийн штаб цэргийн мэргэжлийн удирдлагаар хуулийн дагуу ханган ажиллаж, хорооны цэргийн бүртгэлийн хэсгийн ажиллах цагийн хуваарийг баталгаажуулан ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд явуулахаар зохион байгуулан, өдөр бүр салбар, комиссын гишүүд хариуцсан хорооны цэргийн бүртгэлийн явц үр дүн, иргэний мэдээллийн баяжилт, шинээр бүртгэгдэж байгаа иргэдэд хөтлөгдөж байгаа маягтуудын хөтлөлтөд хяналт тогтоон ажилласан.

**Цэргийн бүртгэлийн тоон үзүүлэлт:**

2021 оны цэргийн бүртгэлд хамрагдсан цэргийн үүрэгтний тоо:



**Хэвлэл, мэдээлэл сурталчилгааны ажил:** 2021 оны цэргийн бүртгэл явуулах тухай зар сурталчилгааг төвлөрсөн худалдааны цэгүүд, томоохон ААНБ, хороодын байр, хэсэг гудамж, хүн ам олноор төвлөрсөн газруудад мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Цэргийн бүртгэлийн зорилго, ач холбогдол, явцын талаар МҮОНТ, TV-5, NTV, гэсэн телевизүүдэд мэдээлэл өгч, цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилсан мэдээ мэдээллийг явуулсан.

Мөн дүүрэг хорооны Фейсбууک хуудас, байр, СӨХ, хорооны группууд, Khan-Uul.mn веб сайт, UBM-FM-89.3 радио зэрэг цахим мэдээллийн сувгуудыг ашиглан энэ жилийн Цэргийн бүртгэлийн онцлог, иргэд хэрхэн цэргийн бүртгэлдээ хамрагдах, шинээр цэргийн бүртгэлд хамрагдах иргэд хэрхэн бүртгүүлэх талаар мэдээ мэдээллийг дэлгэрэнгүй түгээж ажилласан.

Дүүргийн хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар бүртгэлийн ажлыг цаг хугацаанд нь явуулж, дүүргийн хэмжээнд **91.2** хувийн хамралттай бүртгэлийн ажлыг зохион байгуулсан.

**Цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан байдал:**

Хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1995 онд төрсөн иргэд, 2020 онд цэргийн албаны мөнгөн төлбөр тогтоолгон төлөөгүй 1994 онд төрсөн иргэдийн нэрийн жагсаалтыг гарган Цэргийн албаны тухай хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлэн, иргэдийг хүлээн авч, цэргийн алба хаалгах ажлыг зохион байгууллаа.

Мэдэгдлээр дуудсан иргэдийг дүүргийн 21 хороонд өдөр тус бүрээр хуваарь гарган 2021 оны 05 дугаар сарын 19-31-ний өдрүүдэд дүүргийн Спорт хорооны байранд ариутгал халдвартайжүүлэлтийг баримтлан хүлээн авч, батлан хамгаалах хууль тогтоомжийг танилцуулан цэргийн албаны мөнгөн төлбөр тогтоож, хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс чөлөөлж ажилласан.

2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар нийслэлийн Төрийн санд **56** иргэнээр **49,361,441** төгрөгийг төлүүлж, төвлөрүүлээд байна.

Цэргийн албаны тухай хуулийн дагуу цэргийн албаны мөнгөн төлбөрөөс **48** иргэнийг чөлөөлж холбогдох баримт бичгийг хавтаст хэрэгт бүрдүүлсэн.

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа байдал

№		2021
1	Мөнгөн төлбөр тогтоосон	331 иргэн
2	Мөнгөн төлбөр төлсөн	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 56 иргэний 49,361,411 төгрөг төвлөрүүлсэн
3	Мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн	48 иргэн

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдал

№		2019	2020	2021
1	Алба хаасан	6	10	6
2	Алба хааж байгаа болон шинээр элссэн	2	10	6
3	Одоогоор 18 иргэн дүйцүүлэх албыг биеэр хааж байна.			

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэд үүрэг гүйцэтгэх хугацаанд дараах үйл ажиллагаанд оролцсон. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан тоон даалгаврын дагуу дүүргийн Засаг даргын 2021 оны А/246 дугаар захирамжаар 6 иргэнийг цэргийн дүйцүүлэх алба хаалгахаар элсүүлэн гэрээ байгуулсан.

Дүүргийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаасан 4 иргэнийг цэргийн жинхэнэ албыг биеэр дүйцүүлэн хааснаар тооцон халж, цэргийн 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэлд авсан.

Цэргийн дүйцүүлэх албыг 24 сар хааж хугацаа дуусган халагдсан 4 иргэнд Цэргийн штабын дарга, хурандаа Г.Жаргалсайхан талархал, мөнгөн урамшуулал, цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардуулсан.

2021 онд элссэн цэргийн дүйцүүлэх алба хаагч нартай 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр цахимаар сургалтыг зохион байгуулсан.

### Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран ажилласан байдал:

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа алба хаагчдад дүүргийн Засаг даргын мэндчилгээ болон коронавируст халдвартын тархалтаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2000 ширхэг амны хаалт, 800 ширхэг амин дэм вакус, 200 ширхэг гар ариутгач, ариутгалын иж бүрэн хэрэгслийг Цэргийн штабын дарга, хурандаа Г.Жаргалсайхан 2021 оны 03 дугаар 18-ны өдөр ангийн удирдлага болон цэргийн алба хаагчдад гардуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб Зэвсэгт хүчний 336 дугаар ангитай хамтран тус дүүргээс 2020 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанад татагдсан 17 дайчдыг ар гэрийнхэнтэй нь "ZOOM" апплекейшн ашиглан 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр цахимаар уулзуулах ажлыг зохион байгуулсан.

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагчаар ажиллаж байгаад чөлөөнд гарсан бэлтгэл хурандаа Д.Дондовт дүүргийн Засаг даргын дурсамж, гарын бэлгийг төлөвлөлт, сургалтын офицер, ахмад Э.Бат-Эрдэнэ 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр хүргэж, хүндэтгэл үзүүлсэн.

Цэргийн штабын дарга хурандаа Г.Жаргалсайхан дүүргийн 2-р хороонд ажиллан "НЭГ ХААЛГА-НЭГ ШИНЖИЛГЭЭ"-нд иргэдийг үе шаттай зохион байгуулан 2021 оны 02 дугаар сарын 11,12,13-ны өдрүүдийн байдлаар нийт 1,627 иргэнийг PCR шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хороонд 2021 оны 01 дүгээр 14-ний өдөр гурав хоногийн хугацаатай "Тэг зогсолт" буюу хэсэгчилсэн хязгаарлалт хийх шийдвэр гарсаны дагуу 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Баянзүрх дүүргийн 17 дугаар хороонд тус Цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицер, ахмад Э.Бат-Эрдэнэ цэргийн албыг биеэр дүйцүүлэх 10 алба хаагчийн хамт дэмжлэг үзүүлэн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2021 оны А/05 дугаар тушаалаар 2021 оны 02 дугаар сарын 04-нөөс 18-ны өдрүүдэд, 2021 оны А/07 дугаар тушаалаар Баянгол дүүргийн 2 дугаар хороонд байрлах "Тоёоко Инн" зочид буудалд тусгаарлалт, ажиглалтад байсан, мөн БНСҮ-аас тусгай үүргийн онгоцоор ирж тусгаарлагдсан иргэдэд 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицер, ахмад Э.Бат-Эрдэнэ, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч 4 иргэн нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй өдрийн 4 удаа халуун хоол хүргэх үүргийг тус тус гүйцэтгэсэн.

Үүрэг гүйцэтгэх хугацаанд хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын шингэн, нэг удаагийн амны хаалт, малгай, бээлий, нүүрний хаалт, улавчаар бие бүрэлдэхүүнийг бүрэн хангаж ажилласан.

**Цэргийн ар гэрт үзүүлэх халамж үйлчилгээ, халагдсан дайчдыг ажлын байраар хангасан талаар:**

/давхардсан тоогоор/

Хороод	Байнгын ажлын байранд зуучилсан, оруулсан	Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан	Эд материалын тусламж үзүүлсэн	Бусад халамж үйлчилгээ	Нийт
1-р хороо	-	4	6	5	15
2-р хороо	-	2	1	1	4

3-р хороо	-	-	3	-	3
4-р хороо	-	2	-	1	3
5-р хороо	-	1	1	1	3
6-р хороо	1	-	5	1	7
7-р хороо	1	5	4	6	16
8-р хороо	-	2	4	5	11
9-р хороо	-	-	10 шуудай гурил /250кг/ 5 өрх	1	6
10-р хороо	-	8	3 тн сайжруулсан түлш 3 өрхөд	3	14
11-р хороо	-	1	400 кг сайжруулсан түлш 1 өрхөд	-	2
12-р хороо	1	1	2.5 тн сайжруулсан түлш 5 өрхөд	2	9
13-р хороо	-	3	-	-	3
14-р хороо	-	9	2.5 тн сайжруулсан түлш 3 өрхөд	-	12
15-р хороо	-	-	2	-	2
16-р хороо		5	6	2	13
17-р хороо	-	-	-	-	-
18-р хороо	-	-	-	-	-
19-р хороо	1	-	2 шуудай гурил /20кг/ 2 өрхөд	1	4
20-р хороо	-	2	2	-	1
21-р хороо	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>4</b>	<b>28</b>	<b>51</b>	<b>29</b>	<b>112</b>

#### Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын талаар:

Төрийн албаны тухай хуулийн дагуу ажилтны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын архивын ажлын төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2021 оны цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтыг сахин ажиллах хурээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

Төрийн болон албаны нууцын тухай хууль, цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр цэргийн бүртгэлийн нэгдсэн семинарыг цахимаар хийж, дүүргийн 21 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт танилцуулга хийн зөвлөмж өгч, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа /маягт №2/-г бэлтгэж, нууцын баталгаа гаргуулсан.

Дүүргийн 21 хороонд тоо бүртгэлийн офицерын хамт ажиллан цэргийн бүртгэлийн тэмдэг, хорооны мэдээллийн сангийн нууц мэдээлэл тээгчийг бүртгэлээр хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт хүлээлгэн өгч, мөн бүртгэлийн үед хорооны мэдээллийн сангийн цахим зөөвөрлөгчийг ажилтнууд хүлээлцэх бүртгэлийн дэвтэр, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах зөвлөмж зэргийг бэлтгэн хүлээлгэн өгч, өдөр тутмын зөвлөмжөөр ханган ажилласанаар ямар нэг зөрчил дутагдалгүй зохион байгуулагдсан.

Цэргийн штабын даргаар батлагдсан хуваарийн дагуу хариуцсан хороонд / 5, 6, 7, 8, 9 / хяналт тавин хороонд 3 удаа ажиллаж, цэргийн бүртгэлийн үеийн хариуцлагатай жижүүрийн үүргийг 4 удаа гүйцэтгэсэн.

**Төрийн болон албаны нууцын тухай хууль, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:**

Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг судлан албан тушаалтан бүрийн биелүүлэх эрх, үүрэг ажилдаа мөрдөх заавар журмуудыг судлуулан, нууцын баталгаа авах, ажил үүргийн хуваарьт нь тусгах мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2020 онд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн н/01 дүгээр албан бичгээр Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 30 хувьтай байна.

Цэргийн штабын мэдээлэл боловсруулдаг компьютерүүдэд Мэдээллийн технологи, цахим сан хариуцсан мэргэжилтнээр албан ёсны эрхтэй вирусны программыг суулгуулж бүртгэлийг /маягт №19/ хөтөлсөн.

Цэргийн штабын албаны цахим хаягийн нууц үгийг 2 удаа шинэчлэн цахим хаягийн ажиллагааг хэвийн болгож, албаны мэдээллийг солилцож ажилласан.

**Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын хэрэгжилтийн хүрээнд:**

Дайчилгааны нууц бичиг хэргийн өрөө нь "Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 10.1 дэх хэсэг, "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын 17 дугаар бүлгийн 17.1, 17.2, 17.4, 17.11- /а, б, в, г, д, е/-ийн заалтуудын дагуу биет хамгаалалтын шаардлагад нийцүүлэн төхөөрөмжилж, гол унтраах багаж хэрэгсэл, сейф, цахим мэдээлэл боловсруулах техник хэрэгслээр хангагдсан нь нууц баримт бичиг боловсруулах, хадгалах, олшуулах, төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын шаардлагыг ханган ажилласан.

Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөө түүнд холбогдох баримт бичиг, Засаг даргын Тамгын газрын албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтыг боловсруулж танилцах эрхийн түвшинг тогтоон дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын холбогдох ажилтан, хорооны Засаг дарга нар, цугларах, шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнд Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын холбогдох заалт, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 4 дүгээр бүлгийн 4.3.2, 4.3.4 дэх заалтыг танилцуулан эрх, үүрэг, хориглох зүйлийг танилцуулан зааварчилгаа өгч хүн нэг бүрээр баталгаа гаргуулсан.

"Нэгтгэл анги, аймаг, хотын цэргийн хэлтсийн дайчилгааны заавар"-ыг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн н/01, "Зэвсэгт хүчний нууцын бэлэн байдал, нууцын горимын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, шалгаж, үнэлэх заавар"-ыг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн н/21 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт тус тус хураалгаж, данс бүртгэлд хөдөлгөөнийг тэмдэглэсэн.

Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратеги төлөвлөлтийн газраас тус дүүргийн Цэргийн штабт дайчилгааны даалгаврын тоо баримтыг шинэчлэн ирүүлсэнийг бүртгэж, "Баримт бичиг буцаах тодорхойлолт"-д заагдсан маш нууц зэрэглэлтэй баримт бичгийг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн н/20 дугаар албан бичгээр БСТГ-ын нууцад хураалгасан.

Цэргийн штабын бие бүрэлдэхүүнд шинээр батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг танилцуулан 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хичээл зааж, харилцан ярилцлага зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/53 дугаар тушаалаар томилогдсон тооллогын ажлын хэсгийн ахлагчид хурандаа Г.Жаргалсайхан, гишүүдэд хошууч Н.Насанбат, ахлах ахлагч М.Төрмандах нарын бүрэлдэхүүнтэй комисс Цэргийн штабын дайчилгааны бичиг хэрэгт хадгалагдаж байгаа дайчилгааны бэлэн байдлын онц чухал-маш нууц, маш нууц, нууц ном, баримт бичгийн 2021 оны эхний хагас жилийн тооллогыг 05 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд явуулж, тооллогын өгүүлбэр, хүснэгт актыг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлсэн.

**Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчиний үйл ажиллагааг сурталчилсан талаар:**

**А.** 2021 оны цэргийн бүртгэл явуулах тухай зар сурталчилгааг төвлөрсөн худалдааны цэгүүд, томоохон ААНБ, хороодын байр, хэсэг гудамж, хүн ам олноор төвлөрсөн газруудад байршуулж, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Цэргийн бүртгэлийн зорилго, ач холбогдол, явцын талаар МҮОНТ, TV-5, NTV, гэсэн телевизүүдэд мэдээлэл өгч, цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилсан мэдээ мэдээллийг явуулсан.

**Б.** Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны ойг тохиолдуулан “Гурван үеийн уулзалт” нэвтрүүлгийг “NTV” телевизитэй хамтран 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан.

Тус нэвтрүүлэгт Зэвсэгт хүчиний 120 дугаар ангийн захирагчаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Д.Дондов, Зэвсэгт хүчиний 120 дугаар ангийн дивизоны захирагч, дэд хурандаа Д.Төмөрхуяг, мөн ангийн салааны захирагчийн орлогч, түрүүч П.Дөлгөөнсүх нарыг оролцуулсан.

“Гурван үеийн уулзалт” нэвтрүүлэг 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр “NTV” телевизээр цацагдсан.

Өдөр тутмын “Соёмбо мэдээ” цахим сонинд мэдээг бэлтгэн нийтлүүлсэн.

**В.** Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Цэргийн штабын түүхэн замналын самбарын эхийг бэлтгэн хэвлүүлж, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргаар ажиллаж байсан үе үеийн дарга нарыг гэрэл зургийг “Монгол Фото” студиэр хэвлүүлэн жаазлан Цэргийн штабын даргын өрөөнд байрлуулсан.

**Д.** Монгол улсад Генерал цол бий болсны 77 жилийн ойг тохиолдуулан Хан-Уул дүүрэгт оршин суудаг 15 генерал цолтонгуудад дүүргийн Засаг даргын мэндчилгээг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Khan-Uul.mn веб сайт, Фейсбүүк хуудасаар дамжуулан мэндчилгээ дэвшүүлсэн.

• 2021 оныг “Төрийн батлан хамгаалах үйлчилгээ-Цахим шинэчлэлийн жил” болгосонтой холбогдуулан боловсруулсан төлөвлөгөөнд эхний хагас жилд тусгасан ажил үйлчилгээг 55 хувь хэрэгжүүлсэн.

**Цэргийн штабаас аж ахуйн нэгж байгууллагуудад цэргийн үүргийн биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн дүнгийн талаар:**

**А.** 2021 оны эхний хагас жилийн байдлаар Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад 2 байгууллагын 18-50 насны 91 цэргийн үүрэгтний

нээсийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 65,1 хувийг хамруулснаас 34,2 хувь нь зөрчилтэй байсан.

1972-1995 онд төрсөн 4 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосон.

№	Байгууллага нэгжийн нэр	Хүний тоо	ЦЖА хаасан	ЦДА хаасан	Мөнгөн төлбөрөөр хаасан	Цэргийн алба хаагаагүй	Илрүүлсэн зөрчил			Мөнгөн төлбөр			
							Тоо бүртгэлд ороогүй	Цэрэг татлаганд ороогүй	ЦҮ үнэмлэхгүй	Шилжилт хөдөлгөөн хийгээгүй	Төлбөр төлөх хүний тоо /мөнгөн дун/	Төлсэн хүний тоо /мөнгөн дун/	
1	"Цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨХК	67	32	2	18	17	4	-	2	7	3/21654 74	-	3/21654 74
2	Хан-Уул дүүргийн татварын хэлтэс	24	17	-	5	2	-	-	1	3	1/63371 6	-	1/63337 16
	БҮГД	91	49	2	23	19	4	-	3	10	4/2,799, 190	-	4/2,799, 190

**3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:**

2021 оны эхний хагас жилд хүний нөөцийн чиглэлээр нийт 173 тушаалын төслийг боловсруулж батлуулсан. Үүнээс ажлаас чөлөөлөх тухай-57, ажилд томилох тухай-61, шилжүүлэн ажиллуулах тухай-5, ажлаас чөлөөлж, ажилд томилсон тухай-17, буцалтгүй тусламжтай холбоотой-11, цалин шинэчлэх тухай-1, чөлөө олгох тухай-2, сахилгын шийтгэл ногдуулах тухай-2, төрийн хугацааны нэмэгдэл олгох тухай-4, зэрэг дэвийн нэмэгдэл шинэчлэн олгох тухай-2, илүү цагийн нэмэгдэл олгох тухай-4, нэмэгдэл олгох тухай-2, жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай-6, урамшуулалт олгох тухай-1 тушаалыг тус тус боловсруулан батлуулсан.

Дүүргийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр батлуулж, дүүргийн [www.khanuu.mn](http://www.khanuu.mn) цахим хуудасны ил тод буланд байршуулсан. Төлөвлөгөөнд 6 чиглэлийн 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг хянах, ажлын бүтэээмжийг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдын мэдээллийг нутгийн захиргааны байгууллагуудын дотооддоо ашиглаж буй ERP нэгдсэн системд бүртгэсэн.

Засаг даргын Тамгын газрын 76 албан хаагчдын хувийн мэдээллийг хянаж ERP системд бүртгэн, тухай бүр мэдээллийг шинэчлэн оруулсан.

Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг төрийн албаны зөвлөлийн [www.hr.csc.gov.mn](http://www.hr.csc.gov.mn) хаягт 2020 оны 01 дүгээр сард албан хаагчдын мэдээллийг бүрэн шинэчлэж оруулсан.

Албан хаагчдад зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай саналыг Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 сарын 25-ны өдрийн 04/86 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Төрийн албан хаагчдад сахилга хариуцлага дэг журмыг сахиулах, ажлын байран дахь хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор ажлын сахилга хариуцлага, цаг ашиглалтыг сайжруулах тухай чиглэлийг дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад 2021 оны 05 дугаар сарын 03-ны 04/615 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлуулсан. Мөн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор "Хан-Уул дүүргийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах нийтлэг журам"-ыг батлуулсан.

ХАСХОМ-ийг 2021 оны шинэчлэн гаргах мэдүүлгийг хуулийн үйлчлэлд хамаарах 116 албан тушаалтнаас авч, цахим системд бүртгэн баталгаажуулсан.

Төрийн албаны шинэчилсэн хуулийн хүрээнд Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог дүүргийн Засаг даргын 2021 оны А/01 дүгээр захирамжаар шинэчлэн баталж, хэлтэс, албадын уялдаа холбоог сайжруулах ажлыг судлан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн чиг үүрэг, ажлын байрны шинжилгээг зохион байгуулж, албан тушаалын харьцуулалтыг Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газар, дүүргийн 21 хороо, дүүргийн Засаг даргын харьяа байгууллагууд, ОНӨААТҮГ зэрэг нийт 25 байгууллагын 650 албан хаагчдын ажиллах хуваарь, тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн 2021.04.13-ны өдөр ERP системээр дамжуулан НЭДТГ-т хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газар, 21 хороод, дэргэдэх хэлтэс албад, төрийн өмчийн сургууль, цэцэрлэг зэрэг нийт 116 байгууллагын бүтэц, орон тоо, тэдгээрт ажиллаж байгаа 4690 төрийн албан хаагчдын хүний нөөцийн бүрэлдэхүүн, байршил, ангилал зэрэглэлийн судалгааг гаргаж мэдээллийг Төрийн албаны нийслэл дэх салбар зөвлөлийн холбогдох цахим хаягт 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хүргүүлсэн.

#### **Албан хаагчдыг сургалтад хамрагдсан байдал:**

Засаг даргын Тамгын газрын 3 албан хаагчийг Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч, "Албан хэрэг хөтлөлт", "Ёс зүй", "Excel програм", "Өргөдөл гомдлын системийн ашиглалт", "Худалдан авах ажиллагааны А3" зэрэг сургалтуудад давхардсан тоогоор 51 албан хаагчийг хамруулсан.

#### **3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захирагааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэх болон түүнээс бага хугацаагаар шийдвэрлэхийг зорин ажиллаж байна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны хагас жилийн байдлаар иргэдээс нийт 1282 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлжээ. Үүнээс 67 өргөдөл судлагдах




шатандаа, 1207 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 8 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 07 хоног 13 цаг 04 минут байна.

Шийдвэрлэлтийг хоногоор авч үзвэл:



Өргөдлийг санал, хүсэлтээр ангилж үзвэл:



Өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэхэд анхаарч 7 хоног бүрийн сондгой тоотой өдрүүдэд нийтлэг тохиолддог шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтөх болон өргөдөл гомдлыг удирдлагын түвшинд шуурхай шилжүүлж байх, хугацаа хэтрэхээс урьдчилан сэргийлэх, буцаалтын төлөвийн алдааны талаар мэдээлэл өгч, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлж ажиллахыг анхааруулсан.

Мөн дүүргийн 21 хороодыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн систем” ERP программаар иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээ авч, шийдвэрлэх, уламжлах ажлыг жигдруулэхэд анхаарч 14 хоног бүр хороодын Засаг дарга нар болон бичиг хэргийн “Өргөдөл гомдлын нэгдсэн систем”-д иргэний санал, гомдол, хүсэлтийг оруулах, шуурхай шийдвэрлэх, дээд байгууллагад уламжлах талаар мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг статистикийн мэдээлэлд нийтлүүлж байна.

**Өргөдөл гомдлыг дүүргийн хэмжээнд авч үзвэл:**

Хэлтэс, алба	Нийт	Эзлэх хувь	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн			Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	FP1,2,3,4 зөрччиний тоон Узүүлэлт	30 хоногт шийдвэрлэсэн өргөдөл гомдлын
			Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсан	Бүгд	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Бүгд			
ИТХ	19	2.9	0	0	0	19	0	19	08x 21ц 33м	15	19
ЗДТГ	395	17	34	0	34	356	5	361	07x 09ц 28м	209	361
1 дүгээр хороо	1	0.3	0	0	0	1	0	1	13x 05ц 01м	0	1
3 дугаар хороо	4	0.1	0	0	0	4	0	4	04x 10ц 50м	3	4
6 дугаар хороо	2	0.2	0	0	0	2	0	2	01x 11ц 31м	0	2
8 дугаар хороо	25	2.5	0	0	0	25	0	25	00x 06ц 44м	0	25
9 дүгээр хороо	2	1.3	0	0	0	2	0	2	00x 00ц 12м	0	2
13 дугаар хороо	1	0.1	0	0	0	1	0	1	01x 19ц 18м	3	1
14 дүгээр хороо	3	1.2	0	0	0	3	0	3	02x 23ц 43м	3	3
15 дугаар хороо	2	1.2	0	0	0	2	0	2	11x 00ц 28м	0	2
16 дугаар хороо	1	1.0	0	0	0	1	0	1	27x 03ц 34м	2	1
19 дүгээр хороо	1	0.1	0	0	0	1	0	1	04x 00ц 02м	0	1

Газар зохион байгуулалтын алба	280	30.5	11	0	54	268	1	269	08x 06ц 35м	35	269
Цагдаагийн нэдүгээр хэлтэс	19	0.7	0	0	0	19	0	19	07x 08ц 36м	3	19
Цагдаагийн хоёрдугаар хэлтэс	4	0.2	0	0	0	4	0	4	15x 18ц 54м	0	4
Онцгой байдлын хэлтэс	2	0.2	0	0	0	2	0	2	08x 23ц 45м	2	2
Улсын бүртгэлийн хэлтэс	16	1.2	1	0	1	15	0	15	03x 14ц 14м	8	15
Татварын хэлтэс	51	3.9	0	0	0	51	0	51	04x 07ц 58м	49	51
Эрүүл мэндийн төв	63	3.3	6	0	6	56	1	57	09x 04ц 52м	52	57
Нийгмийн даатгалын хэлтэс	30	2.1	1	0	1	29	0	29	01x 12ц 35м	1	29
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	12	3.5	0	0	0	12	0	12	01x 05ц 39м	3	12
Мэргэжлийн хяналтын хэлтэс	239	13	9	0	9	229	1	230	06x 01ц 07м	39	230
Боловсролын хэлтэс	4	0.5	0	0	0	4	0	4	06x 03ц 17м	1	4
Дүүргийн нэгдсан эмнэлэг	13	0.8	6	0	0	13	0	13	03x 04ц 24м	6	13
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	5	0.9	0	0	0	5	0	5	02x 10ц 09м	0	5
Биеийн тамир, спорт хороо	5	0.8	0	0	0	5	0	5	00x 19ц 43м	0	5
Усан спорт сургалтын төв ОНӨҮҮГ	5	0.3	0	0	0	5	0	5	00x 08ц 41м	0	5
Гэр бүл, хүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	28	1.8	2	0	2	26	0	26	11x 12ц 41м	13	26
Дотоод аудитын алба	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Албан бус-Насан туршийн боловсролын төв	13	1	0	0	0	13	0	13	07x 22ц 18м	21	13
Статистикийн хэлтэс	0	0.1	0	0	0	1	0	1	0	0	0
Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	2	0.2	0	0	0	2	0	2	15x 09ц 47м	2	2
Нийтлэг үйлчилгээний алба-ОНӨААТҮГ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хан-Уул Агро ОНӨААТҮГ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Нийт</b>	<b>1282</b>	<b>100</b>	<b>66</b>	<b>1</b>	<b>67</b>	<b>1207</b>	<b>8</b>	<b>1215</b>	<b>07x 13ц 04м</b>	<b>571</b>	<b>1215</b>

**Иргэдэд мөнгөн тусlamж үзүүлсэн тухай:** "Дүүргийн Засаг даргаас иргэдэд үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусlamж үзүүлэх тухай журам"-ыг шинэчлэн боловсруулж, Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн A/189 дүгээр захирамжаар батлуулан мөрдөж байгаа бөгөөд журамд заасны дагуу хороодын Хөгжлийн нийгмийн ажилтнууд мөнгөн тусlamж хүссэн иргэдийн гэрээр очиж судлан нөхцөл байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр, 2021 оны тайлант хугацаанд нийт 33 иргэнд 11.700.000 /Арван нэгэн сая долоон зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусlamж үзүүлсэн байна. Үүнд:

1. 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн A/114 дүгээр захирамжаар 27 иргэнд 9.000.000 төгрөг
2. 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн A/186 дугаар захирамжаар 6 иргэнд 2.700.000 төгрөг тус тус олгосон байна

### 3.4 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл:

Харилцахын 614 ширхэг баримтаар 2,868,012,293 төгрөгийн гүйлгээг хянан баталгаажуулсан.



Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн 16 ширхэг баримтаар 243,454,686 төгрөгийн гүйлгээг хянан баталгаажуулсан.




Засаг даргын Тамгын газрын нийт 155 төрийн албан хаагч, 185 хэсгийн ахлагчийн цалин, амралтыг хянан баталгаажуулсан



ЗДТГазрын нэмэлт санхүүжилтын дансаар 6 ширхэг баримтаар 117,284,00 төгрөгийн гүйлгээг хянан баталгаажуулсан.



2021 оны 1,2,3,4,5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж баталгаажуулсан.



Бараа материалын 344,247 ширхэг баримтаар 358,284,958 төгрөгийн зарлагыг гүйлгээг шаардах хуудасны дагуу хянасан.



1-р улиралын ХХОАТ тайланг хугацаанд нь илгээж баталгаажуулан, Автомашины татвар болон бусад татвар хураамжуудыг цаг тухай бүрт төлөлт хийн татварын өр үүсгэлгүй ажилласан.

Тамгын газрын нийт 360 ажилтны НДД дэвтрийн бичилтийг хийн баталгаажуулж, 2021 оны 1,2,3,4,5 саруудын тайланг хугацаанд нь хянан баталгаажуулсан.

Шилэн дансны мэдээлэлийн сайтад 1-5 сарын мэдээлэлийг хугацаанд нь оруулсан.

Бараа материалын 782 ширхэг баримтаар 20,627,397 төгрөгийн шилжилт хөдөлгөөнийг хянан баталгаажуулсан.

- Үндсэн хөрөнгийн 209 удаагийн 249,613,317 төгрөгийн орлогын гүйлгээг хянан баталгаажуулсан.
- Үндсэн хөрөнгийн 787.58 ширхэг 2,336,714,475.6 төгрөгийн эд хөрөнгийн шилжүүлт хөдөлгөөнийг хянан баталгаажуулсан.
- 2020 оны 1-р улиралын барьцаа хөрөнгө, байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланг гаргаж Санхүү төрийн сангийн хэлтэст тушааж баталгаажуулсан.
- Засаг даргын Тамгын газар болон хороодын нийт 42 албан хаагчийн ажлыг хүлээлцүүлж 461,908,389.08 төгрөгийн шилжилт хөдөлгөөн хянасан.
- Хэлтэс албад болон жолооч нарын 2021 оны 1-6 сарын хугацаанд 27,448,000 шуурхай штабын 12,595,000 төгрөгийн шатахууны тооцоог бодож шалгасан.
- Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан.
- 2021 оны 1-р улиралын санхүүгийн тайланг хянасан баталгаажуулсан.
- Дүүргийн хороодын 1,2 улирлын бичиг хэрэг аж ахуйн материалыг тараасан.
- Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан.
- 2021 оны хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгийн 209 ширхэг нийт 249,613,316.82 төгрөгийн эд хөрөнгийг бүртгэн авч 293 ширхэг нийт 268,217,408.79 төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэрийн дагуу хасалт хийсэн болно.

#### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

##### **4.1 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:**

**Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгууллаа:**

Монгол Улсын Засгийн газар болон Хан-Уул дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулах, иргэдээс төрийн үйлчилгээний талаар гаргаж байгаа санал гомдол, санаачлагыг тусгах, тэднээс мэдээлэл авах, түгээх эрхийг хангах зорилгоор Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар 7 телевиз, 24 цахим сайтаар дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, Онцгой комиссын онцлох мэдээ, сурвалжлага, шууд дамжуулалт, тодруулга зэрэг 119 мэдээ, мэдээллийг шуурхай хүргэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны [www.khanuul.mn](http://www.khanuul.mn) цахим сайтыг бүрэн шинэчилсэн.



[www.khanuul.mn](http://www.khanuul.mn), Хан-Уул Эко дүүрэг, Хан-Уул дүүргийн иргэдийн бүлэг, Хан-Уул дүүргийн Шуурхай штаб, Нээлттэй Хан-Уул зэрэг цахим хуудасуудад 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 852 мэдээ, нийтлэл, ярилцлага, сурвалжлага, лайв, тодруулга, зөвлөмж, зөвлөгөөг нэгтгэн боловсруулж, хянан байршуулсан.

Цахим хуудаст шинээр “Хан-Уул дүүргийн Түүхэн замнал” цэс нээж ТАНИН МЭДЭХҮЙН булангаараа дамжуулан мэдээ, мэдээллийг түгээсэн.

Мөн “Цахим Хан-Уул” буланг шинээр нээж, төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэн, иргэдээс ирсэн санал, хүсэлтийг хүлээн авч, асуултад тогтмол хариулан ажиллаж байна.

#### Цаг үеийн холбогдолтой нэлөөллийн контент бэлтгэн ажилласан:

Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс, Хан-Уул дүүргийн Онцгой комиссын цаг үеийн холбогдолтой тогтоол, шийдвэр, үйл ажиллагааг Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэн, шаардлагатай мэдээлэл, зөвлөмжийг бэлтгэн ажиллалаа. Үүнд:

1. Ковид 19-тэй холбоотой цаг үеийн нэлөөллийн 105 ширхэг зөвлөмж, постер, контент, видео бэлтгэн хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр тухай бүр нь мэдээлсэн. Үүнд:
  - Сэтгэлзүйчийн зөвлөгөө 8, дохионы хэлбэрээр видео контент, зөвлөгөө, мэдээлэл 28, олны танил урлаг соёлын эрхмүүдээр дамжуулан нэлөөллийн 36 видео контент бэлтгэсэн.




Засаг даргын Тамгын газар болон цаг үеийн холбогдолтой үйл ажиллагааны нийт 15 мэдээлэл, мэндчилгээг тухай бүр нь хургэсэн.

Улс, Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын мэдээллийг тухай бүр нь иргэдэд мэдээллэж, нийт 56 видео, контент, постор бэлтгэсэн.



## ЦАХИМ САН, ОЛОН НИЙТИЙН ЧИГЛЭЛЭР:


Хан-Уул дүүргийн албан ёсны цахим хуудсууд болох Хан-Уул Эко дүүрэг, Хан-Уул дүүргийн иргэдийн бүлэг, Хан-Уул дүүргийн Шуурхай штаб, Нээлттэй Хан-Уул зэрэг нийт 4 цахим хуудсаар дамжуулан дүүргийн иргэдээс 1159 санал, хүсэлт, өргөдлийг холбогдох мэргэжилтнүүдэд мэдэгдэж, асуултад тухай бүр нь 24 цагаар хариулан цахимаар Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй хүргэн ажилласан.



2021 оны эхний хагас жилийн байдлаар Хан-Уул Эко дүүрэг цахим хуудсаар дамжуулан 710,856 иргэн хандан мэдээлэл авсан байна. Нийт 3,948 иргэн комментоор, 3,481 чатаар тус тус асуулт асууж, холбогдох мэргэжилтнүүд хариуг тухай бүр хүргэж ажилласан.



Хан-Ул дүүргийн Шуурхай штаб хуудсаар дамжуулан КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал, өдөр тутмын мэдээлэл, зөвлөгөө зөвлөмж, шинжилгээ авах, вакцинжуулалттай холбоотой зар, мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэсэн. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1,025 мэдээллийг байршуулж, дунджаар 954,103 иргэн хандаж, 4,650 коммент 3,975 иргэн чатаар асуулт ируулсэн байна.



Хан-Уул дүүргийн иргэд цахим бүлгэм 24,963 (+326) гишүүнтэй болсон бөгөөд дунджаар +417,000 удаа иргэн хандаж холбогдох асуултыг асуух, хариулт авсан байна.



"Нээлттэй Хан-Уул" буюу дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотой үйл ажиллагааны 115 мэдээ, видео, контент бэлтгэн хяналт тавин ажилласан.




[www.khanuuul.mn](http://www.khanuuul.mn) Фээсбүүк бот чаттай болж, 21 хороодын нэгдсэн чатбот үйлчилгээг нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан.



[www.Khanuuul.mn](http://www.Khanuuul.mn) цахим сайтад видео бичлэг, лайв мэдээлэл, төрийн үйлчилгээ зэрэг иргэдэд нэн шаардлагатай мэдээ, мэдээллийг байршуулж байгаа бөгөөд иргэд тухайн мэдээллийг 24 цагийн турш нөхөж үзэх боломжтой болсон.

Төрийн үйлчилгээний нэр төрөл, бүрдүүлэх материалын жагсаалт, албан хаагчидтай холбогдох утасны дугаар зэргийг иргэд гар утаснаасаа цаг алдалгүй авах боломжтой болсон.



## ТАВДУГААР БҮЛЭГ

### 5.1 Холбогдох чиг үүргийн дагуу нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл:

Нэг цэгийн үйлчилгээний танхимины үйл ажиллагааны чиглэлээр:

"Нэг цэгийн үйлчилгээ"-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган 2021 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 14177 иргэн үйлчилүүлсэн байна. Тус төвөөр өдөрт 100-300 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд цар тахалтай холбогдуулан дээрх үзүүлэлт буурсан. Төрийн үйлчилгээний мэдээлэл лавлагаа, Өргөдөл гомдол хүлээн авах төв, Эд хөрөнгийн бүртгэл, гэрчилгээ олгох Гадаад паспорт хүлээн авах, олгох, Нотариат, Кадастр, Зурагчин, канон зэрэг 7 цонхоор 43 төрлийн үйлчилгээ хүргэж байна.

### 5.4 Хөрөнгө санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл, болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээлэл:

Хүндрэлтэй асуудлууд:

- Хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн асуудлаар зохион байгуулах шаардлага гарч буй арга хэмжээнүүд тухайн жилийн батлагдсан төсөөт тусгагдаагүй байдаг тул шийдвэрлэхэд хүндрэлтэй, цаг хугацаа тулсан байдаг.

2. Дээд газруудаас ирж байгаа олон нийтийг хамарсан болон бусад цаг үеийн шинжтэй ажил зохион байгуулах, биелэлт, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичгүүдийн хугацаа тулж ирүүлдэг.

**Цаашид анхаарах асуудлууд:**

1. Зохион байгуулж буй үйл ажиллагааны үр дүн, ач холбогдолын талаар иргэдээс тухай бүр санал асуулга авч, түүний мөрөөр дүн шинжилгээ хийж ажлаа төлөвлөх
2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын албан хаагчид, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх
3. Төлөвлөсөн ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэл сайтай хийж гүйцэтгэх, үр дуна тооцож ажиллах
4. Зохион байгуулах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тоогтмол сурталчилж, олон нийтэд ил тод мэдээлж байх

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.САРАНГУА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.АРИУНЖАРГАЛ